

Агуулга

Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын Нийцлийн аудитын газар

НАГ-ын захирлын
албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч
Х.Болдбаатар

Ахлах аудитор
Я.Наранцэцэг

Аудитор
Л.Нямтөмөр
Ц.Цэрэннамжил

2018 оны 03 дугаар
сар

Тайланг ҮАГ-ын веб
сайт-аас үзнэ үү.
www.audit.mn

Аудитын тайлан,
дүгнэлттэй
холбоотой асуудлаар
нэмж тодруулах,
асууж лавлах зүйл
байвал 261729
дугаарын утас,
260949 дугаарын
факсаар
харилцана уу.

Хаяг:
Үндэсний аудитын
газар
Засгийн газрын 4
дүгээр
байр,
Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар 15160,
Монгол улс

Товчилсон үгийн жагсаалт	3
Аудит хийх үндэслэл.....	4
Аудитын зорилт.....	4
Аудитын хамрах хүрээ.....	4
Аудитын арга зүй.....	4
Үндсэн мэдээлэл.....	5-8
Бүлэг. 1 Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөж, боловсруулаагүй байна.....	9-20
1.1 Хуульд заасан төсөл боловсруулах үе шатанд тавигдах шаардлагыг орхигдуулан журмын дагуу төлөвлөгөө гаргаж байна.....	9
1.2 Нөхцөл байдлын шинжилгээ нь тулгамдсан асуудлыг тодорхойлоогүй, баримт бичгүүдэд бодлогын олон хувилбар боловсруулалгүй зөвхөн нэг хувилбарыг тодорхойлж түүндээ нэмэлт өөрчлөлт хийх замаар гаргаж байна.....	9-12
1.3 Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ нь судалгаанд суурилаагүй, хэрэгжсэнээр ямар үр дүнд хүрэх нь хэмжигдэхүйц биш байгаагаас үнэлэх боломжгүй байна.....	12-13
1.4 Хуулийн 6 дугаар зүйлд заасан бодлогын баримт бичгийн төрөл тус бүрт санхүүжилт, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байхаар заасныг ХББББНЖ-д нэг бүрчлэн тодорхойлоогүй байна.....	13-19
1.5 Журамд заасан боловсруулалтын шатны шаардлагыг хангаагүй байхад зөвшөөрөл олгож байна.....	19
1.6 Журамд заасан шаардлагуудад нийцүүлэн санал авч, хянан боловсруулах шаардлагатай байна.....	19-20
Бүлэг 2. Бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтээр нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шаардлагатай байна.....	21-25
2.1. Зарим бодлогын баримт бичигт 2017 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ үнэлгээ хийж холбогдох байгууллагад тайлагнасан байна.....	21-23
2.2. ХББББНЖ-д заасан боловсруулалтын шатны шаардлагыг хангаагүйгээс хяналт-шинжилгээ үнэлгээг БББХЗБҮАХШҮХНЖ-ын дагуу үнэлж байгаа нь бодитой биш байна.....	23-24

2.3 Ихэнх бодлогын баримт бичгийн хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, тайлагнах хугацаа болоогүй байна.....	24-25
Бүлэг 3. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтлөх журмыг боловсруулж гаргаагүй байна.....	26-29
3.1 Бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг тухайн асуудал хариуцсан захиргааны байгууллага хариуцан зохион байгуулж байна.....	26
3.2 Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хууль, журамд заасан үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна.....	26-29
Дүгнэлт.....	30
Зөвлөмж.....	31
Холбогдох байгууллагын санал.....	32-34
МУЕА-ын тушаал.....	35
Хавсралтууд.....	36-43

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АТГ	Авлигатай тэмцэх газар
БББ	Бодлогын баримт бичиг
БББХЗБҮАХШҮХНЖ	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам /хуучнаар/
БСШУСЯ	Боловсрол соёл шинжлэх ухаан, спортын яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
ЖСЗ	Жендэрийн салбар зөвлөл
ЖСХ	Жендэрийн салбар хороо
ЖЭТБХТХ	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗТЯ	Зам тээврийн яам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУТХҮБ	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
МУИХ	Монгол Улсын их хурал
НЗДТГ	Нийслэлийн засаг даргын тамгын газар
ХНХЯ	Хөдөлмөр нийгэм хамгааллын яам
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ХБББНЖ	Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулан нийтлэх журам
ХБТТХ	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
ХБӨ	Халдварт бус өвчин
ХХААХҮЯ	Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтэс
ХШҮДАХ	Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
ХШҮ	Хяналт-шинжилгээ үнэлгээ
СЯ	Сангийн яам
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
ТТХ	Төсвийн тухай хууль
УИХ	Улсын их хурал
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

ХҮСНЭГТ, ГРАФИК, ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	Бодлогын баримт бичгийн судалгаа
Хүснэгт 2	Аудитад хамрагдсан бодлогын баримт бичгийн тоо
Хүснэгт 3	1 дүгээр бүлгийн 1.2 дахь дэд сэдвийн жишээ
Хүснэгт 4	1 дүгээр бүлгийн 1.3 дахь дэд сэдвийн жишээ
Хүснэгт 5	1 дүгээр бүлгийн 1.6 дахь дэд сэдвийн жишээ
Хүснэгт 6	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хуулийн заалт, хугацаа
Хүснэгт 7	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хуулийн хугацаа болсон баримт бичиг
Хүснэгт 8	2 дугаар бүлгийн 2.1 дэх дэд сэдвийн жишээ

Аудит хийх үндэслэл

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2017 онд хийх аудитын төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн эсэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөж, боловсруулан баталсан эсэх;
- Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх;
- Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж байгаа эсэх.

Хамарсан хүрээ

Аудитад Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөгдөж эхэлсэн 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш боловсруулан баталж, хэрэгжиж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар болон холбогдох яам, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, түүний харьяа агентлаг, байгууллага, Засаг даргын Тамгын газрыг хамруулан шалгалаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, 400, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашиглан аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан болно.

Аудитын дүн дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

- Төсвийн тухай хууль;
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Хууль тогтоомжийн тухай хууль;
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль;
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Улсын Их Хурлын 2016 оны 19 дугаар тогтоол “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”;

- Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоол “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай”;
- Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”;
- Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”;
- Засгийн газрын 2016-2020 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх “Үндэсний хөтөлбөр”-ийн жагсаалт;
- Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;
- Ерөнхий сайдын 2016 оны 38 дугаар захирамжаар батлагдсан Үндэсний хөгжлийн газрын зохион байгуулалтын бүтэц, Үндэсний хөгжлийн газрын “Үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”;
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.

Үндсэн мэдээлэл

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн зорилт чиглэсэн байна.

Бодлогын баримт бичгийг боловсруулахад Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ыг баримталж бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус мөрдөж байна.

Аудитын урьдчилсан судалгааны үе шатанд Үндэсний хөгжлийн газрын 2017 оны 08 дугаар сарын 01/753 дугаар албан бичиг, аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газраас авсан судалгааны дүнг нэгтгэхэд үндэсний, салбарын болон салбар хоорондын, аймаг, нийслэлийн түвшинд урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх 774 орчим хөгжлийн бодлогын баримт бичиг хүчин төгөлдөр байгаагаас ХБТТХ хэрэгжиж эхэлснээс хойш 634 бодлогын баримт бичиг, тэдгээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө баталсан.

Бодлогын баримт бичгийн судалгаа

Хүснэгт 1

Бодлогын баримт бичгийн төрөл	Бодлогын баримт бичиг	Аудитын өмнөх судалгаа		Аудитаар	
		Нийт	Хууль хэрэгжиж эхэлснээс хойш	Нийт	Хууль хэрэгжиж эхэлснээс хойш
Урт хугацааны буюу 15-20 жилийн хугацаанд хэрэгжүүлэх /Хуулийн 6.1.1/	Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал /Хуулийн 7 дугаар зүйл/	4	1	1	1

Дунд хугацааны буюу 8-10 жилийн хугацаанд хэрэгжүүлэх /Хуулийн 6.1.2/	Төрөөс баримтлах бодлого /Хуулийн 8 дугаар зүйл/	31	5	35	14
	Бүсчилсэн хөгжлийн бодлого /Хуулийн 13 дугаар зүйл/	1	-	1	-
	Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт /Хуулийн 14 дугаар зүйл/	32	14	62	10
	Сум, дүүргийн түвшинд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх орон нутгийн онцлогийг тусгасан хөгжлийн дунд хугацааны бодлого /Хуулийн 14 дугаар зүйл/	72	50	14	1
Дунд хугацааны буюу 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх /Хуулийн 6.1.2/	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /Хуулийн 9 дугаар зүйл/	1	1	1	1
	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /Хуулийн 15 дугаар зүйл/	335	333	308	308
	Үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөр /Хуулийн 10 дугаар зүйл/	94	26	70+ 265	33+265
	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр /Хуулийн 11 дүгээр зүйл/	1	1	1	-
Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх /Хуулийн 6.1.3/	Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл /Хуулийн 12 дугаар зүйл/	1	1	2	2
	Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл /Хуулийн 16 дугаар зүйл/	201	201	217	217
	Улс, орон нутгийн төсөв	1	1	-	-
ХБТТХ-ийн БББ-т хамаарагдахгүй		Дээрх дүнд нэгтгэгдсэн		64	9
Нийт		774	634	1041	861 /60+801/

Хуулийн 14, 15, 16 дугаар зүйлд хамаарах бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшинд, урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх 640 бодлогын баримт бичиг аудитын урьдчилсан судалгаанд нэгтгэгдсэн бол аудитаар аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газраас ирүүлсэн судалгаагаар нийт 866 үүнээс 801 бодлогын баримт бичиг нь хууль батлагдсанаас хойш гарсан байна. /Хавсралт №1/

Аймаг, нийслэлийн Төрийн аудитын газраас хууль хэрэгжиж эхэлснээс хойших 801 бодлогын баримт бичигт аудит хийж давхардсан тоогоор 282 албан тушаалтанд 120 заалт бүхий зөвлөмж, 3 албан тушаалтанд зөрчил арилгуулах, 2 албан тушаалтанд сахилгын шийтгэл ноогдуулах тухай албан шаардлагыг тус тус хүргүүлснийг нэгтгэн ажлын баримтад хавсаргав.

Үндэсний болон салбар, салбар хоорондын түвшинд урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх 162 бодлогын баримт бичиг аудитын урьдчилсан судалгаанд нэгтгэгдсэн бол аудитаар яам, агентлагаас авсан жагсаалтаар хууль

батлагдсанаас хойш батлагдсан 13 бодлогын баримт бичиг нэмэгдэж¹ нийт 175 баримт бичиг хамрагдсан.

Нийт бодлогын баримт бичгийг баталсан субъектээр нь авч үзвэл ЗГ-ын 108, УИХ-ын 57, боловсруулж байгаа 10 баримт бичиг тус тус байна. /Хавсралт №3/

Бодлогын баримт бичгийн төрөл	Аудитад хамрагдсан бодлогын баримт бичгийн тоо									Хүснэгт №2
	A	B	Нийт	C	C1	C2	D	Нийт	Хассан	Аудитад хамрагдсан
Хөгжлийн үзэл баримтлал /ХБТТХ-7/	1	-	1	-	-	-	1	1	-	1
Төрөөс баримтлах бодлого /ХБТТХ-8/	29	6	35	23	21	2	12	14	-	14
Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал /ХБТТХ-9/	1	-	1	1	1	-	-	-	-	-
ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр /ХБТТХ-10/	1	-	1	-	-	-	1	1	-	1
Үндэсний хөтөлбөр /ХБТТХ-11/	62	6	68	37	35	2	31	33	-	33
Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр /ХБТТХ-12/	1	-	1	1	1	-	-	-	-	-
Улсын ЭЗНХҮЧиглэл /ХБТТХ-13/	2	-	2	-	-	-	2	2	-	2
Дэд хөтөлбөр, ХБТТХ-д хамрагдахгүй	65	1	2+64	50	50	-	16	16	7	9
БҮГД	162	13	175	112	108	4	63	67	7	60

A – Аудитын өмнөх судалаа B - Аудитаар нэмэгдсэн C – ХБТТХ батлагдахаас өмнө C1 - Нэмэлт өөрчлөлт хийгдээгүй C2 - нэмэлт өөрчлөлт хийгдэж байгаа D – ХБТТХ батлагдсанаас хойших баримт бичиг C2 - нэмэлт өөрчлөлт хийгдэж байгаа D – ХБТТХ батлагдсанаас хойших баримт бичиг Хассан – Хассан үндэслэл нь

Бодлогын баримт бичгийн төрлөөр ангилан үзвэл хөгжлийн үзэл баримтлал 1, төрөөс баримтлах бодлого 35, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал 1, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 1, Үндэсний хөтөлбөр 68, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр 1, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл 2, дэд хөтөлбөр 2, бодлогын баримт бичигт хамаарахгүй 64 баримт бичиг байна. /Хавсралт №4/

Бодлогын баримт бичигт хамаарахгүй 64 баримт бичгийн 49 нь хууль батлагдахаас өмнө, 14 нь хууль батлагдсаны дараа, нэг нь шинээр нэмэгдсэн баримт бичиг байна. /Хавсралт №5/

Нийт 175 баримт бичгээс ХБТТХ батлагдахаас өмнө 112, ХБТТХ батлагдсанаас хойш 63, үүнээс 13 баримт бичиг нь Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам /ХБББНЖ/ батлагдахаас өмнө боловсруулагдсан байна. /Хавсралт №6/

Хууль батлагдахаас өмнө боловсруулагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 112 баримт бичгийн хувьд УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” /МУТХҮБ-2030/-ийн 2.2-т “Монгол улсын их хурал болон Засгийн газраас баталсан үндэсний хэмжээний болон салбарын, салбар дундын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг энэхүү үзэл баримтлалд нийцсэн эсэхийг 2016 онд багтаан хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн боловсруулах” гэж заасны дагуу ХБТТХ, ХБББНЖ-ыг баримтлан өөрчлөлт хийсэн байдлыг үзвэл 108 баримт бичиг

¹ Хавсралт №2

нь нэмэлт өөрчлөлт хийгдээгүй, 4 баримт бичиг нь нэмэлт өөрчлөлт хийгдэх түвшинд байна. /Хавсралт №7/

ХБТТХ хэрэгжиж эхэлснээс хойших 63 баримт бичиг дээр, хууль батлагдахаас өмнөх өөрчлөлт хийгдэж байгаа 4 буюу нийт 67 баримт бичиг аудитад хамрагдахаас нууцын зэрэгтэй болон хөгжлийн бодлогын баримт бичгийн төрөлд хамаарахгүй гэсэн шалтгаанаар 7 баримт бичиг хасагдаж нийт 60 бодлогын баримт бичигт аудит хийлээ./Хавсралт №8/

Аудитад бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжүүлэлт, хяналт-шинжилгээ үнэлгээнд судалгаа хийлгэх зорилгоор шинжээч авч ажиллуулсан бөгөөд тайлангийн бүтцэд жишээ болгож шинжээчийн тайлангаас дурдсан болно.

Мөн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, боловсруулалтад шинжилгээ хийхдээ ХБТТХ-ийн 17 дугаар зүйлд заасан боловсруулах дарааллын дагуу 5 багц үзүүлэлтийг 100% гэж үзэн заалт тус бүрт оноо өгөн эзлэх хувиар үнэлсэн бөгөөд хууль хэрэгжиж эхэлснээс хойших 60 бодлогын баримт бичгийг 25.09% гэж дүгнэсэн байна. Бодлогын баримт бичиг бүрт өгсөн үнэлгээг хавсралт №9-д үзүүлэв.

Шинжээчийн багаас хуулийн хэрэгжилтийг ХБТТХ болон хөгжлийн үзэл баримтлал батлагдсантай холбогдуулан хөгжлийн бодлогыг уялдуулах, зарим шаардлагагүй бодлогыг зогсоох, шинэчлэх боловсруулах ажил удаашралтай байгаа бөгөөд шинээр батлагдаж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгүүд бүхэлдээ ХБТТХ-ийн 17 дугаар зүйл болон журамд тавигдсан хэлбэрийн шаардлагыг хангаж байгаа боловч тэдгээрийн чанарын шаардлагыг шалгавал хангалтгүй үнэлгээтэй байна гэсэн ерөнхий дүгнэлт өгсөн байна.

Аудитыг гүйцэтгэхэд тулгарсан хүндрэл

ХБТТХ-ийн хэрэгжилтэд хийх аудитын явцад дараах хүндрэл, бэрхшээл тулгарлаа.

- Аудитын явцад багийн гишүүд 2-3 аудит зэрэг хийж ирсэн нь аудит хийхэд хүндрэл учруулж байсан,
- Бодлогын баримт бичгийг боловсруулсан мэргэжилтнүүд солигдсон,
- Баримт бичгийн боловсруулалтын шатны ажлын баримт материалд архивын нэгж үүсгэдэггүйгээс шаардсан материал гаргахад цаг хугацаа алдсан,
- ХБТТХ-ийн хэрэгжилтэд хийсэн аудитын хамрах хүрээний хувьд хуулийг бүхэлд нь хамруулан шалгасан нь өргөн цар хүрээтэй болж ажлын ачаалал үүсч байлаа. Цаашид ХБТТХ-д аудит хийхдээ нэг удаагийн аудитаар 1-2 бодлогын баримт бичигт аудит хийх нь аудитын чанарт сайнаар нөлөөлөхөөр байна.

БҮЛЭГ. 1 ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨЖ, БОЛОВСРУУЛААГҮЙ БАЙНА.

1.1. Хуульд заасан төсөл боловсруулах үе шатанд тавигдах шаардлагыг орхигдуулан журмын дагуу төлөвлөгөө гаргаж байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль (ХБТТХ)-ийн 17 дугаар зүйлийн 17.1.4²-т хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг оновчтой бодлогын хувилбарт үндэслэн нарийвчлан төлөвлөж боловсруулна гэж заасан.

Харин Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам (ХББББНЖ)-ын 9.1-д *“төсөл” гэж захиргааны байгууллагаас боловсруулж байгаа энэ журмын 1-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн эх бичвэрийг*” хэлнэ гэж заасан байна.

Хууль, журмын дээрх заалтаас харахад оновчтой бодлогын хувилбарт үндэслэн захиргааны байгууллагаас боловсруулж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн эх бичвэрийг нарийвчлан төлөвлөж боловсруулахаар заасан байхад журмын 17³, 18⁴-д зааснаар холбогдох материалуудыг бүрдүүлэх төдий төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Өөрөөр хэлбэл захиргааны байгууллагаас боловсруулагдсан баримт бичгүүдийн төсөл нь оновчтой хувилбарт үндэслэхгүйгээр ажлын хэсэг нь төсөл боловсруулах төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, 17.1.4-т бодлогын баримт бичиг боловсруулах үе шатыг нарийвчлан тусгасан байхад журмын 18-д заасан төсөл боловсруулах төлөвлөгөөнд эдгээр заалтыг орхигдуулсан нь хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх нөхцөлийг хязгаарласан байна. Тухайлбал:

ХБТТХ батлагдсанаас хойших бодлогын баримт бичгүүдэд хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, 17.1.4-т заасны дагуу бодлогын хувилбаруудыг боловсруулж тэдгээрийг шалгуур үзүүлэлтээр үнэлж оновчтой бодлогын хувилбар сонгогдоогүй. Энэ журмын 18.5-д заасан ерөнхий заалттай холбоотой байна.

Иймд хуульд заасан боловсруулалтын үе шатны дагуу холбогдох заалтуудыг журамд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

1.2 Нөхцөл байдлын шинжилгээ нь тулгамдсан асуудлыг тодорхойлоогүй, баримт бичгүүдэд бодлогын олон хувилбар боловсруулалгүй зөвхөн нэг хувилбарыг тодорхойлж түүндээ нэмэлт өөрчлөлт хийх замаар гаргаж байна.

ХБТТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.1-17.2⁵-т заасны дагуу хөгжлийн бодлогын баримт бичгийг 5 үе шат, тавигдах шаардлагын дагуу боловсруулахаар заасан байна.

² хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг оновчтой бодлогын хувилбарт үндэслэн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам, үе шат, түүнд шаардлагатай нөөцийг нарийвчлан төлөвлөж боловсруулна.

³ Энэ журмын 12, 13-т заасан Ажлын хэсэг нь төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөтэй байна.

⁴ Төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа болон хариуцан гүйцэтгэх, оролцох талын нэрийн хамт тусгана:

⁵ ХБТТХ-ийн 17.1.1-д заасны дагуу тулгамдсан асуудал тодорхойлох

Мөн хуулийн 17.1.2-т заасны дагуу бодлогын хувилбар боловсруулах

Мөн хуулийн 17.1.3-д заасны дагуу бодлогын оновчтой хувилбар сонгох

Мөн хуулийн 17.1.4-т заасны дагуу бодлогын оновчтой хувилбарыг төлөвлөх

Мөн хуулийн 17.2-т заасны дагуу боловсруулалтын явц нь зохих шатны байгууллагаар хянагдаж батлагдаж байгааг шалгах шаардлагыг хангах

Мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1⁶ -т бодлогын баримт бичиг боловсруулах цар хүрээг тодорхойлох, холбогдох тоон болон чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх гэж заасныг ХБББНЖ-ын 23⁷-т тулгамдсан асуудлыг нөхцөл байдлын шинжилгээгээр тодорхойлохоор нарийвчлан тусгасан байна.

Гэвч нөхцөл байдлын шинжилгээг журмын 9.3⁸-т асуудлын шалтгаан, үр нөлөө, хамрах хүрээг тодорхойлсон судалгаа байна гэж заасан байхад хууль батлагдсанаас хойш боловсруулагдсан хөгжлийн бодлогын баримт бичгүүд нь тухайн цаг үеийн нөхцөл байдлыг тоочсон, асуудлын шалтгааныг дурдсан боловч шалтгаан бүрийн асуудалд нөлөөлөх нөлөөллийн хэмжээг тодорхойлоогүй байна. Тухайлбал:

Хүснэгт №3

Хуулийн заалт	Бодлогын баримт бичгийн нэр	Нөхцөл байдлын шинжилгээг хийсэн байдал	Дүгнэлт
Хуулийн 8 дугаар зүйлд заасан “Төрөөс баримтлах бодлого”	Засгийн газрын 2017 оны 295-р тогтоолоор батлагдсан БСШУЯ-ны “Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого”	Улсын хэмжээнд технологийн асуудлыг нэгтгэн зангидах төрийн байгууллагын статус тодорхой бус байгаагаас технологийн бодлого эзэнгүйдэж, үүнтэй холбоотойгоор технологийн аюулгүй байдал алдагдаж, гадаадаас орж ирж байгаа технологид хяналт тавих, технологийн үнэлгээ хийх, нутагшуулах, ашиглах үйл ажиллагаанд тавих хяналт сул байна. ⁹ ...гаднаас болон дотооддоо технологи дамжуулах үйл ажиллагаа сул, арга механизм төлөвшөөгүй байгаа нь шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа хөгжүүлэхэд саад учруулж байна. ¹⁰	Асуудлын шалтгаан, үр нөлөөг дүгнэлт хэсэгтээ тодорхойлсон боловч тэдгээрийн хоорондын уялдаа холбоо, хамаарлыг хэмжээг гаргаагүй, баримт нотолгоогоор баталгаажуулсан байдал тусгагдаагүй байна. Дүгнэлт хэсэгт дурдагдсан тоон мэдээллүүдийн эх сурвалжууд дурдагдаагүй байна. Гэвч бодит байдалд бодлогын баримт бичгийн нэг л төсөл боловсруулагдаж, улмаар тухайн төсөлд нэмэлт өөрчлөлт хийх байдлаар сайжруулан хэлэлцүүлэгдэж батлагдаж байна.
	Засгийн газрын 2017 оны 24-р тогтоолоор батлагдсан Эрүүл мэндийн яамны “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”	Нийгмийн эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр нилээд олон үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр заасан хэдий ч өнөөгийн байдлаар аймаг, сум, дүүргийн хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтвортой бүтцийг бий болгох талаарх үйл ажиллагаа хангалтгүй байгаа юм. ¹¹	Асуудлын шалтгааныг дурдсан боловч шалтгаан бүрийн асуудалд нөлөөлөх нөлөөллийн хэмжээг тодорхойлоогүй. Асуудлын үр нөлөөг тодорхойлсон ч нотолгоогүй, энгийн логигоор уялдуулж тодорхойлсон. Нөхцөл байдлын шинжилгээний тайланд тоон мэдээллүүдийн эх

⁶ хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл, тулгамдаж байгаа асуудал, бэрхшээлийн цар хүрээг тодорхойлох, холбогдох тоон болон чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх;

⁷ Нөхцөл байдлын дүн шинжилгээ нь тухайн асуудлаар хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл, шаардлагыг гаргасан тулгамдсан асуудлыг мэдэрч тодорхойлсон баримт бичиг байна.

⁸ “нөхцөл байдлын дүн шинжилгээ” гэж асуудлын шалтгаан, үр нөлөөг тоон болон чанарын мэдээлэлд үндэслэн хамрах хүрээний хамт тодорхойлсон бодлогын хувилбар боловсруулахад ашиглах судалгааг;

⁹ “Монгол Улсын шинжлэх ухаан технологийн салбарын нөхцөл байдлын үнэлгээ” товч тайлан, Улаанбаатар 2017, хуудас 15

¹⁰ “Монгол Улсын шинжлэх ухаан технологийн салбарын нөхцөл байдлын үнэлгээ” товч тайлан, Улаанбаатар 2017, хуудас 15

¹¹ “Эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал”-ын нөхцөл байдлын дүн шинжилгээ, Улаанбаатар хот 2016 он, хуудас 8

		Улаанбаатар хотын гэр хорооллын хүн амын хэт нягтрал, суурьшлаас хамааран хөрс, газрын гүний усны бохирдол өндөр, ундны усыг зориулалтын бус саванд хадгалж байгаа зэрэг нь усны чанар аюулгүй байдлыг алдагдуулж, хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг нэмэгдүүлсээр байна. ¹²	сурвалжууд дурдагдаагүй. Мөн нөхцөл байдлын шинжилгээний тайланд боловсруулсан болон гүйцэтгэхэд оролцсон талуудыг дурдаагүй нь журмын 14-р зүйлд заасан шаардлагыг хангаагүй байна.
Хуулийн 10 дугаар зүйлд заасан “Үндэсний хөтөлбөр”	ЗТЯ-ны боловсруулж буй “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”	МУ-ын ерөнхий зориулалтын нисэхийн түүхэн хэрэглээ, бусад салбарын тулгамдсан асуудлыг дурдсан боловч хүндрэл бэрхшээл болох гол асуудал хөндөгдөөгүй.	Судалгаанд ямар нэгэн асуудлын шалтгааныг тодорхойлсон зүйл байхгүй. Асуудлыг дүрслэх байдлаар өөр салбарын тулгамдсан асуудлыг тодорхойлсон боловч үүнийг шийдвэрлэхэд яагаад Ерөнхий зориулалтын нисэхийн салбарыг хөгжүүлэх шалтгааныг тодорхойлоогүй.

Дээрх хүснэгтээс үзэхэд нөхцөл байдлын шинжилгээг хийхдээ тулгамдсан асуудлын мөн чанар, шалтгаан хүчин зүйлсийн харилцан хамаарлыг тодорхойлолгүй, ерөнхий нөхцөл байдлын төлөвийг тоочсон, хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хэт ерөнхий тодорхойлж судалгаа хийдэггүй зэрэг нь хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4¹³, журмын 22¹⁴-т заасныг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

Өмнө нь хэрэгжсэн бодлого яагаад амжилтад хүрээгүй, түүнд ямар хүчин зүйлс нөлөөлсөн, түүнийг зохицуулах ямар оролдлого хийсэн. Энэ оролдлого нь эерэг эсвэл сөрөг үр нөлөө бий болгосон талаар дүгнэн бичсэн тохиолдол байхгүй байна.

Нөхцөл байдлын шинжилгээнд үндэслэн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх бодлогын хувилбарыг боловсруулахаар ХБТТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.1.2¹⁵ -т заасныг ХБББНЖ-ын 18.2¹⁶ -т нөхцөл байдлын дүн шинжилгээнд үндэслэн хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг тодорхойлох, 18.3¹⁷-т зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хувилбар боловсруулна гэж нарийвчлан тусгасан нь агуулгын хувьд зөрчилдөж байна.

Хуулийн дээрх заалт нь ХБББНЖ-ын 9.13-т *“бодлогын хувилбар гэж нөхцөл байдлын дүн шинжилгээ болон нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд үндэслэн асуудлыг шийдвэрлэхээр санал болгосон бодлогын 2-оос дээш сонголтуудыг”* гэж тодорхойлсонтой зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2-т эхлээд бодлогын хувилбар боловсруулахаар заасан байхад журмын 9.13-т эхэлж нөлөөллийн урьдчилсан үнэлгээг боловсруулахаар заасан байна.

¹² “Эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал”-ын нөхцөл байдлын дүн шинжилгээ, Улаанбаатар хот 2016 он, хуудас 11

¹³ судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;

¹⁴ Төслийн нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх ... иш татсан тохиолдолд бодлогын баримт бичиг болон судалгаа, мэдээллийн эх сурвалжийг заана.

¹⁵ “асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, гарах үр дүн, үр нөлөөг, эдийн засаг, нийгмийн хөгжлийн загвар, төсөөлөлд үндэслэн бодлогын хувилбарыг боловсруулах”;

¹⁶ нөхцөл байдлын дүн шинжилгээнд үндэслэн хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг тодорхойлох;

¹⁷ хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх бодлогын хувилбаруудыг боловсруулах;

Мөн журмын 9.13 дахь заалтыг нь тус журмын 18.4-т “бодлогын хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийх” гэж заасантай харьцуулахад логик дарааллын хувьд аль нь эхэлж хийгдэх нь тодорхойгүй байна.

ХБТТХ батлагдсанаас хойших бодлогын баримт бичгүүдэд бодлогын олон хувилбар боловсруулалгүй зөвхөн нэг хувилбарыг тодорхойлж түүндээ нэмэлт өөрчлөлт хийх замаар гаргаж байна.

Иймд хууль, журмын дээрх заалтуудын агуулгын болон логик дарааллын зөрчилтэй байдлыг залруулах шаардлагатай байна.

1.3 Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ нь судалгаанд суурилагүй, хэрэгжсэнээр ямар үр дүнд хүрэх нь хэмжигдэхүйц биш байгаагаас үнэлэх боломжгүй байна.

Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ гэдэг нь ХБББНЖ-ын 9.12¹⁸-т зааснаар бодлогыг хэрэгжүүлснээр гарах үр нөлөөг эдийн засаг, нийгэм, байгаль, байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эрх зүйн орчин тус бүрээр тодорхойлсон судалгаа байхаар томъёолсон байна.

ХБББНЖ-ын 18.4¹⁹-т нөлөөллийн урьдчилсан үнэлгээг бодлогын хувилбар бүрт зориулан хийхээр заасан боловч ХБТТХ-ийн 17.1.3-т бодлогын хувилбаруудыг тусгайлан заасан 5 шалгуур үзүүлэлтэд тусгалгүйгээр сонгохоор заасан нь уг үнэлгээний ач холбогдол (яах гэж, юунд зориулж хийж байгаа вэ?)-ыг үгүйсгэсэн. Мөн ХБББНЖ-ын 18.5-т “хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах” гэж заасан нь бодлогын аль хувилбар (нэг хувилбарт уу? хэд хэдэн хувилбарт уу? Бүх хувилбарт уу? зөвхөн оновчтой хувилбарт уу?)-т төсөл боловсруулах нь тодорхойгүй байна.

Өөрөөр хэлбэл хуулинд нөлөөллийн урьдчилсан үнэлгээг, журамд бодлогын оновчтой хувилбар сонгох сонголтыг тус тус орхигдуулсан байна.

ХБТТХ батлагдсанаас хойших бодлогын баримт бичгүүдэд бодлогын олон хувилбар хийлгүй зөвхөн нэг хувилбараар боловсруулж түүнд зориулан нөлөөллийн урьдчилсан үнэлгээг журмын 4 дүгээр хавсралтыг бөглөх замаар хэлбэр төдий гүйцэтгэж байна. Тухайлбал:

Хүснэгт №4

Хуулийн заалт	Бодлогын баримт бичгийн нэр	Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийсэн байдал	Дүгнэлт
Хуулийн 8 дугаар зүйлд заасан “Төрөөс баримтлах бодлого”	Засгийн газрын 2017 оны 320-р тогтоолоор батлагдсан ХНХЯ-ны “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”	...В. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр одоогийн хууль эрх зүйн тогтолцоонд үзүүлэх нөлөө. 3. Төгсөгчдөд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэдлэг боловсрол, ур чадвар олгох ажлын байртай болгоход дэмжлэг үзүүлэх чиг үүргийг дээд боловсролын сургалтын байгууллагад нэмэх ²⁰ ...	Гарчиг нь нөлөө гэсэн үгтэй доторх утга агуулга нь зорилт бичсэн. Энэ нь нөлөөллийн үнэлгээг хийгээгүй зөвхөн хавсралт 4-ийг бөглөх төдий гүйцэтгэж байгааг харуулж байна.
Хуулийн 10 дугаар зүйлд	Засгийн газрын 2017 оны 77-р тогтоолоор	...Хүмүүсийн соёлд дараах нөлөө үзүүлнэ. Үүнд:	Сэргийлэх бололцоог гэдгийг юу гэж ойлгох, юугаар хэмжих вэ?,

¹⁸ “нөлөөллийн урьдчилсан үнэлгээ” гэж бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчин, аливаа байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эрх зүйн орчинд үзүүлэх нөлөөллийн талаарх судалгааг;

¹⁹ бодлогын хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийх;

²⁰ “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ын Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ, 4 дүгээр хавсралтын 6 дугаар тал

<p>заасан “Үндэсний хөтөлбөр”</p>	<p>батлагдсан ХЗДХЯ-ны “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”</p>	<p>Иргэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын талаарх мэдээ, мэдээлэлтэй танилцах, эрх зүйн мэдлэгтэй болсоноор, энэ төрлийн гэмт хэрэг зөрчлөөс сэргийлэх /өөрийгөө болоод бусдыг, ялангуяа хүүхэд, залуучууд/ учирч болох хор аюулаас /бие махбодь, эдийн засаг, сэтгэл зүйн болоод бусад/ сэргийлэх бололцоотой болно²¹...</p>	<p>өнөөгийн байдлаас хэдэн хувиар дээшилж, ямар тувшинд, хэзээ хүрэх нь тодорхойгүй.</p>
	<p>Засгийн газрын 2017 оны 142-р тогтоолоор батлагдсан СЯ-ны “Хөгжлийн зам хөтөлбөр”</p>	<p>...“Хөгжлийн зам” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д туссан нэг хүнд ногдох үндэсний орлого өсч, ядуурлын түвшин, орлогын тэгш бус байдал буурахад нөлөө үзүүлнэ. Мөн цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах болон нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн хэмжээ өсч, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ. Мөн түүнчлэн Монгол Улсад аялах гадаадын жуулчдын тоо өснө²²...</p>	<p>Хэдээр өсөх вэ?, Хэзээ өсөх вэ?, Хэд байснаас хэдээр нэмэгдэх вэ? Өсөх магадлал нь хэдэн хувь вэ? Ямар ямар эрсдлүүд тулгарах вэ? Хөгжлийн замын хөтөлбөр хэрэгжснээс хамаарсныг нь хэрхэн тодорхойлох вэ? зэрэг олон асуудлууд тодорхойгүй, түүгээр ч үл барам ямар судалгаанд үндэслэсэн гэдэг нь хүртэл тодорхойгүй байна.</p>

Дээрх хүснэгтээс үзэхэд ХБТТХ батлагдсанаас хойш боловсруулагдсан бодлогын баримт бичгийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ судалгаанд суурилагагүй, хэрэгжсэнээр ямар үр дүнд хүрэх нь хэмжигдэхүйц биш байгаагаас үнэлэх боломжгүй байгаа нь хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан зарчим болон журмын 26²³ дахь заалттай нийцэхгүй байна.

1.4 Хуулийн 6 дугаар зүйлд заасан бодлогын баримт бичгийн төрөл тус бүрт санхүүжилт, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байхаар заасныг ХБББНЖ-д нэг бүрчлэн тодорхойлоогүй байна.

Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг оновчтой бодлогын хувилбарт үндэслэн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг ХБТТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.1.4²⁴-т нарийвчлан төлөвлөж боловсруулна гэж заасныг ХБББНЖ-ын 52²⁵ -т 8-10 жилийн дунд хугацааны бодлого, үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөрийн агуулга, бүтцийн шаардлагыг дэлгэрүүлэн тодорхойлсон боловч тус журмын 61, 63-т Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн бүтэц, агуулгад тавигдах уг шаардлагыг орхигдуулсан байна. Улмаар журамд тусгагдсан зарим заалтууд ойлгомжгүй байдлыг бий болгож байна. Үүнд:

- Журмын 57, 58-д бодлогын үр дүнг шалгуур үзүүлэлтүүдээр ялгаж тодорхойлохоор заасан байхад журмын 5 дугаар хавсралтад зорилт тус бүрээр шалгуур үзүүлэлтийг тодорхойлохыг шаардсан нь агуулгын хувьд зөрчилдөж байна.

²¹ “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ, Хуудас 1

²² “Хөгжлийн зам хөтөлбөр”-ийн Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ, Хуудас 1

²³ Нөлөөллийн урьдчилсан үнэлгээг өмнө хийсэн судалгаа, үнэлгээ, албан ёсны тоон болон чанарын мэдээлэлд үндэслэн хийнэ.

²⁴ хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг оновчтой бодлогын хувилбарт үндэслэн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам, үе шат, түүнд шаардлагатай нөөцийг нарийвчлан төлөвлөж боловсруулна.

²⁵ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6.3, 6.4.3-т заасан төсөл дараах ерөнхий бүтэц, агуулгатай байна:

- Мөн журмын 65-д “Нутгийн захиргааны байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулахдаа энэхүү журмын 65, 66-д заасныг баримтална” гэж заасан бөгөөд журмын 65, 66-д өөр утга бүхий заалт байгаагаас үндсэн чиглэлийг боловсруулахад ойлгомжгүй байдалд хүргэж байгаа нь уг журмыг хэм хэмжээний актад бүртгэхдээ хянасан эсэх нь тодорхойгүй байна.

Бодлогын баримт бичгийн боловсруулалтад бодлогын үр дүнг бүтээгдэхүүн, үр нөлөө гэж ялгаж ангилахгүйгээр бичих, шалгуур үзүүлэлтүүдийг үр дүн эсвэл бүтээгдэхүүн, үр нөлөө тус бүрээр гаргахгүйгээр зөвхөн шалгуур үзүүлэлтүүдийг нэгдсэн байдлаар нэг хүснэгтэд оруулах, эсвэл зөвхөн журмын 5 дугаар хавсралтыг бөглөх хэлбэрээр боловсруулж байна. Тухайлбал:

Хуулийн 8 дугаар зүйл “Төрөөс баримтлах бодлого”

Төрөөс баримтлах бодлогын 14 баримт бичгүүд дотроос БХБЯ-ны боловсруулж буй “Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын төсөлд бүтээгдэхүүн, үр нөлөөг тодорхойлсон боловч тус бүрт нь шалгуур үзүүлэлт гаргаагүй, БСШУСЯ-ны боловсруулсан “Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг”-ийн төсөлд зөвхөн үр нөлөөг л тодорхойлсон боловч холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг гаргаагүй, тусдаа нэг хүснэгтэнд шалгуур үзүүлэлтүүдийг томъёолсон нь тус тус ХБББНЖ-ын 58 дугаар зүйлтэй заасантай нийцэхгүй байна. Жишээ нь:

ЗГ-ын 2017 оны 295 дугаар тогтоолоор батлагдсан БСШУСЯ-ны “Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого”:

№	Бодлогын зорилт	Шалгуур үзүүлэлт	2017 суурь он	2020 он	2025 он
1.	Шинжлэх ухаан, технологийн салбарын бүтэц, зохион байгуулалтын, менежментийг боловсронгуй болгох;	Салбарын бүтэц, зохион байгуулалт, менежментийг сайжруулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэн төлөвшүүлсэн байна.		+	
2.	Судалгаа боловсруулалтын ажлыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, өрсөлдөх чадварыг эрс дээшлүүлэх	Нэг жилд хэвлүүлсэн нийт бүтээлийн тоо	10000	20000	30000
		Нэг сая хүнд ногдох эрдэм шинжилгээний өгүүлэл тоо	57	150	301

(Эх сурвалж: ирүүлсэн төслийн үндсэн баримт бичгийн 6-7 хуудас)

- “Эрх зүйн орчинг бүрдүүлэн төлөвшүүлсэн байна” гэдэг нь ямар нэгэн шалгуур үзүүлэлт биш, өнгөрсөн цагт бичигдсэн өгүүлбэр буюу дүгнэлт хэлбэртэй байна.
- №2-т дурдсан шалгуур үзүүлэлтүүд нь хэмжигдэж болохуйц нэр томъёог оруулсан боловч журмын 57, 58-т заасан бодлогын үр дүн тус бүрт шалгуур үзүүлэлт тодорхойлно гэсэнтэй нийцэхгүй байна.
- Шалгуур үзүүлэлт бүрийн өгөгдлийг олж авах мэдээллийн эх сурвалжийг заагаагүй, эдгээр шалгуур үзүүлэлтүүд нь журмын 58.5.1²⁶-т заасан МУТХҮБ-ын ямар зорилт, шалгуур үзүүлэлттэй уялдаагүй байна.

Хуулийн 8 дугаар зүйл “Төрөөс баримтлах бодлого”, БХБЯ-ны боловсруулж буй “Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлого”

Энэхүү бодлогын баримт бичгийн 4 дүгээр бүлэгт “Бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт” гэж оруулсан нь:

²⁶ бодлогыг хэрэгжүүлсний үр дүнд гарах өөрчлөлт нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын зорилт, шалгуур үзүүлэлттэй уялдсан байдал;

4.1. Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлтийг бусад бодлогын баримт бичиг, статистикийн мэдээ, салбар, салбар хоорондын мэдээлэлд үндэслэн дараах байдлаар тодорхойлж байна.

4.1.1. Бодлогын үр нөлөө:

4.1.1.1. иргэд, залуу гэр бүл, зорилтот бүлгийг үе шаттайгаар орон сууцжуулснаар хүн амын эрүүл, ая тухтай орчинд амьдрах нөхцөл хангагдаж, ажлын бүтээмж дээшилнэ.

4.1.1.2. дахин барилгажуулах үйл ажиллагаа хэрэгжиж, орон сууцны хангамж нэмэгдэж, хот төлөвлөлт сайжирна. гэх мэт

4.1.2. Бодлогын бүтээгдэхүүн:

4.1.3. Бодлогын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тогтоож, 2014-2015 оны тоон мэдээллүүдийг суурь болгон авч үзнэ:

д/д	Шалгуур үзүүлэлт	2015 суурь он	Нэгдүгээр үе шат /2023 оны түвшинд/	Хоёрдугаар үе шат /2028 оны түвшинд/
1. Орон сууцны талаар				
1	Орон сууцны сан /м2/			
2	Түрээсийн орон сууцны сан /тоогоор/	2000	19000	30000
3	Тохилог орон сууцаар хангагдсан иргэд	30%	40%	50%
4	Хөрөнгийн эх үүсвэрээс шалтгаалан дутуу гүйцэтгэлтэй орон сууцны барилга /хувь/	100%	50%	30%

(Эх сурвалж: ирүүлсэн төслийн үндсэн баримт бичгийн 11 хуудаснаас авав.)

- Бодлогын үр нөлөөг хэмжигдэх боломжгүй байдлаар тодорхойлсон нь түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж ирэх боломжгүй байдал үүсгэж журмын 58.1-д заасан шаардлагыг биелүүлэх төдий байна.
- Мөн шалгуур үзүүлэлтүүдийг тусд нь бичих, юунд, ямар зүйлийг хэмжихэд ашиглагдах нь тодорхойгүй байдал үүсгэснээс ач холбогдолгүй болгож байна.
- Шалгуур үзүүлэлтүүдийн зорилтод түвшинг харахад нөхцөл байдлын шинжилгээтэй хэрхэн уялдсан, нөөц бололцоо, санхүүгийн эх үүсвэртэйгээ уялдуулж гаргаж ирсэн нь тодорхойгүй байна.
- Мөн шалгуур үзүүлэлтийг гүйцэт нэрлэлгүй шууд **иргэд, барилга** гэх мэтээр бичиж байна.

Хуулийн 10 дугаар зүйл “Үндэсний хөтөлбөр”

Үндэсний хөтөлбөрийг боловсруулсан төслийн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг нэг хүснэгтэд оруулж, зөвхөн журмын 5 дугаар хавсралтыг бөглөх хэлбэрээр боловсруулж байгаа нь журмын 57-д заасан бодлого хэрэгжүүлсний үр дүнд бий болох бүтээгдэхүүн, үр нөлөө, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох, мөн журмын 58-д заасан тус бүрт нь шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн, суурь түвшин, он, мэдээллийн эх сурвалж зэргийг тодорхойл гэсэн заасантай тус тус нийцэхгүй байна. Жишээ нь:

ЗГ-ын 2017 оны 289 дүгээр тогтоолоор батлагдсан ЭМЯ-ны “Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”

Уг хөтөлбөрийн 4 дүгээр бүлэгт хөтөлбөрийн үр дүнг хүүрнэх хэлбэрээр илэрхийлсэн боловч үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг тус бүрт нь тодорхойлоогүй нь журмын 57, 58-д заасан шаардлагатай нийцэхгүй байна. Хөтөлбөрийн хэсгээс дурдвал:

... Дөрөв. Хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлт

4.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ...

4.1.9 ХБӨ-ийг эрт илрүүлэхэд шаардагдах зардлын тодорхой хувийг ЭМД-д хамруулснаар эрүүл мэндийн санхүүжилтийн эх үүсвэр нэмэгдэж, иргэд, эрүүл мэндийн байгууллагад үзүүлэх санхүүгийн дарамт багасна.

4.1.10 Хүн амын цэвэр өсөлт нэмэгдсэнээр ажиллах хүчний тоо нэмэгдэж, эдийн засагт эерэгээр нөлөөлнө...

4.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөө, үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр дүгэнэнэ:

№	Шалгуур үзүүлэлт			Хүрэх үзүүлэлт
---	------------------	--	--	----------------

		Эх үүсвэр	Суурь үзүүлэлт	2019 он	2021 он
А.Үр дүнгийн шалгуур үзүүлэлт:					
I.Халдварт бус өвчний анхдагч эрсдэлт хүчин зүйлийн үзүүлэлт:					
1.	Хүн амын тамхины хэрэглээ, хувиар	*	27.1	27.0	26.0
2.	Сүүлийн 30 хоногт тамхийг 1-2 удаа хэрэглэсэн13-15 насны хүүхэд, хувиар	**	5.9	5.4	4.9
3.	Сүүлийн 30 хоногт тамхийг 1-2 удаа хэрэглэсэн 16-17 насны хүүхэд, хувиар	**	17.5	16.0	14.5
4.	Сүүлийн 30 хоногт ажлын байрандаа тамхины утаанд өртөгсөд, хувиар	*	25.5	23.4	21.3

(Эх сурвалж: батлагдсан үндсэн баримт бичгийн 11 хуудаснаас авав.)

(*) Халдварт бус өвчин, осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгаа, 2013 он

(**) Сургуульд суурилсан хүүхдийн эрүүл мэндийн судалгаа, 2016 он

Шалгуур үзүүлэлтийн хувьд төрөөс баримтлах бодлогод гарсан алдаанууд мөн давтагдаж байгаа бөгөөд нэг хүснэгтэд зөвхөн шалгуур үзүүлэлтүүдийг оруулсан, нэр томъёо нь дүгнэсэн өгүүлбэр хэлбэрээр бичигдсэн, суурь үзүүлэлт, хүрэх үр дүн зэргийг орхигдуулсан нийтлэг алдаанууд боловсруулагдсан бүх баримт бичгүүдэд гарч байна.

Иймд хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4.3-т заасан бодлогын баримт бичгийг боловсруулахдаа ХБББНЖ-ын 54, 57, 58-т тусгасан шаардлагуудыг биелүүлж ажиллах шаардлагатай байна.

ХБТТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1²⁷, 18 дугаар зүйлийн 18.1²⁸-д зааснаар хуульд хамаарах бүх бодлогын баримт бичигт санхүүжилт, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байх шаардлагатай байна.

Гэтэл ХБББНЖ-ын 52-т зааснаар хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4.3-т хамаарах бодлогын баримт бичгээс бусад тохиолдолд санхүүжилт, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байх шаардлагыг оруулаагүйгээс санхүүжилт, эх үүсвэрийг өөр өөр хэлбэрээр боловсруулж байна.

Өөрөөр хэлбэл 8-10 жилийн дунд хугацааны бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөрт ХБББНЖ-ын 59²⁹-т зааснаар макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, гадаад өрийн зохистой харьцаа, төсвийн хүрээний мэдэгдэл, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт үндэслэсэн тооцооны хамт тусгаж боловсруулах ёстой боловч бусад бодлогын баримт бичгүүдэд “*нарийвчлан тусгасан байх*” хэмээх ойлголт нь тодорхойгүй байна. Тухайлбал:

Хуулийн 7 дугаар зүйл “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал”

Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “... нөөц, эх үүсвэртэй нь уялдуулан тооцсон хөгжлийн загварт суурилсан байна” гэж заасан боловч нөөц тодорхойлоогүй, санхүүжилтын эх үүсвэр байхгүй мөн хөгжлийн загвар нь тодорхой бус байна.

Хуулийн 8 дугаар зүйл “Төрөөс баримтлах бодлого”

Төрөөс баримтлах бодлого болон бусад бодлогын баримт бичгүүдэд дараах нийтлэг 2 алдааг гаргаж байна.

- Зөвхөн санхүүжилтийн эх үүсвэрүүдийн нэрийг нь заалт хэлбэрээр дурдаж оруулах,
- Санхүүжилтийн эх үүсвэрүүдээс авах мөнгөн дүнг заалт хэлбэрээр оруулах.

²⁷ ... зорилго, зорилт, хүрэх үр дүнг нөөц, эх үүсвэртэй нь уялдуулан тооцсон хөгжлийн загварт суурилсан байна.

²⁸ “Дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигт төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байна”

²⁹ Энэхүү журмын 52.5-д заасан “Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр” бүлэгт дунд хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд тусгагдсан зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг бодлогын зорилт тус бүрээр макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, гадаад өрийн зохистой харьцаа, төсвийн хүрээний мэдэгдэл болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт үндэслэсэн тооцооны хамт тусгасан байна:

Энэ нь журмын 59-д заасан шаардлагатай нийцэхгүй байна. Жишээ нь:

ЗГ-ын 2017 оны 295 дугаар тогтоолоор батлагдсан БСШУСЯ-ны “Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого”:

Үүнийг боловсруулсан төсөлдөө ХБББНЖ-ын 52.5 болон 59 дэх заалтын дагуу хийсэн боловч батлагдсан хувилбартаа санхүүжилтийн талаар байсан заалтуудыг нь хасаж баталсан. Иймэрхүү төслийн боловсруулалт нь батлагдсан хувилбараасаа илүү чанартай байсан бодлогын баримт бичгүүд нилээдгүй байсан. (Журмаараа батлагдсан хувилбар нь ямар шаардлага хангасан байх тухай заагаагүй, зөвхөн бодлогын баримт бичгийн төсөлд тавих шаардлагыг л оруулсан).

Зургаа. Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр

6.1. Судалгаа, боловсруулалтын ажилд зарцуулах санхүүжилтийн Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын тогтвортой хөгжил үзэл баримтлал-2030”-ын “2.2. Нийгмийн тогтвортой хөгжил” бүлгийн “2.2.3. Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн” заалтын 5 дахь зорилтод тусгагдсанаар 2017-2020 онд 2 хувьд, 2021-2025 онд 2.5 хувьд хүргэнэ.

6.2. Монгол улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, Засгийн газрын 2007 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд тусгагдсан зорилтыг үндэс болгон, судалгаа, боловсруулалтын ажилд зарцуулах Засгийн газрын санхүүжилтийн Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2025 он гэхэд 1 хувьд хүргэнэ. Бодлогыг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс 1 их наяд 334 тэрбум төгрөг зарцуулна.

6.3. Бодлогын баримт бичигт тусгагдсан эрдэм шинжилгээний зориулалттай барилга байгууламж, лаборатори, салбарын дэд бүтцийг байгуулах, багаж, тоног төхөөрөмжөөр хангахад 3 их наяд 214 тэрбум төгрөг шаардлагатай.

6.4. Шинжлэх ухааны паркийн дэд бүтцийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, үндсэн барилга, байгууламжийг гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр байгуулна. Шинжлэх ухааны паркийн дэд бүтцийг байгуулахад 91 тэрбум төгрөг зарцуулна.

6.5. Шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг энэ бодлогын 6.2, 6.3, 6.4-д заасныг үндэслэн жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлнэ.

(Эх сурвалж: ирүүлсэн төслийн үндсэн баримт бичгийн 8 дугаар хуудаснаас авав.)

Эдгээр заалтыг төслийн үндсэн баримт бичигтээ оруулсан байгаа боловч батлагдсан үндсэн баримт бичигтээ оруулаагүй, санхүүжилт гэсэн бүлгийг хасаж баталсан. Энэ нь журмын 59-т заасан макро эдийн засгийн төсөөлөл болон гадаадын өрийн зохистой харьцаа зэрэгт үндэслэж байгаа зэргийг нотлохгүй байна. Мөн журмын 2 дугаар хавсралтад заасан санхүүжилтийн эх үүсвэрийг бөглөсөн боловч төслийн үндсэн баримт бичигтээ тусгаагүй зэрэг журмын 52.5-т заасныг зөрчсөн байна.

БХБЯ-ны боловсруулж буй “Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлого”

Энэ бодлогын баримт бичгийн 5 дугаар бүлэгт Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр гэж нэрлээд дараах байдлаар тусгасан байна.

5.1. Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ нь “Ус” үндэсний хөтөлбөр, “Хямд өртөгтэй орон сууц” үндэсний хөтөлбөр болон засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд хэрэгжүүлнэ.

5.2. Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг дараах эх үүсвэрээр санхүүжүүлнэ:

5.1.1. улсын төсөв, хөрөнгө оруулалтын хөтөлбөр

5.1.2. олон улсын банк, санхүүгийн байгууллагын хамтын ажиллагаа

5.1.3. зээл:

5.1.4. төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа

5.2.5. бусад эх үүсвэр.

(Эх сурвалж: ирүүлсэн төслийн үндсэн баримт бичгийн 12 дугаар хуудаснаас авав.)

Энэ нь журмын 59-т заасан шаардлагатай нийцэхгүй байна. Мөн журмын 31³⁰-т заасны дагуу баримт бичгийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг СЯ олгохдоо хяналт хийж байгаа ч хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна. Түүнээс гадна санхүүжилтийн эх үүсвэрийг журмын 2 дугаар хавсралтдаа ихэвчлэн тусгаж оруулж байгаа нь журмын 52.5-д заасан шаардлагыг биелүүлэхгүй байна.

Хуулийн 9 дүгээр зүйл “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан заалт оруулаагүй нь хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 18 дугаар зүйлийн 18.1-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Гэвч тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2016 оны 10 дугаар сарын 26-ны Засгийн газрын 121 дүгээр тогтоол батлахдаа санхүүжилт болон эх үүсвэрүүдийг тусгасан байна.

Хуулийн 10 дугаар зүйл “Үндэсний хөтөлбөр”

Үндэсний хөтөлбөр болон бусад бодлогын баримт бичгүүдэд дараах нийтлэг 2 алдааг гаргаж байна.

- Зөвхөн санхүүжилтийн эх үүсвэрүүдийн нэрийг нь заалт хэлбэрээр дурдаж оруулах,
- Санхүүжилтийн эх үүсвэрүүдээс авах мөнгөн дүнг заалт хэлбэрээр оруулах.

Энэ нь журмын 59-д заасан шаардлагатай нийцэхгүй байна. /Төрөөс баримтлах бодлогод тайлбарласантай адил/ Жишээ нь:

ЗГ-ын 2017 оны 243 дугаар тогтоолоор батлагдсан ХНХЯ-ны “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тав дахь хөтөлбөр”

Тав.Хөтөлбөрийн хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

5.1.Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

5.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.2.1.улсын болон орон нутгийн төсөв;

5.2.2.олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.2.3.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас зарцуулах хөрөнгө;

5.2.4.бусад эх үүсвэр.

(Эх сурвалж: батлагдсан хөтөлбөрийн 9 дүгээр хуудаснаас авав.)

ЗГ-ын 2017 оны 289 дүгээр тогтоолоор батлагдсан ЭМЯ-ны “Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”

Тав.Хөтөлбөрийн санхүүжилт

5.1.Хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

5.1.2.олон улсын болон хандивлагч орнуудын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.1.3.аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, тусламж;

5.1.4.бусад эх үүсвэр.

(Эх сурвалж: батлагдсан хөтөлбөрийн 12 дугаар хуудаснаас авав.)

Энэ нь журмын 59-т заасан шаардлагатай нийцэхгүй байна. Мөн журмын 31³¹-т заасны дагуу баримт бичгийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг СЯ олгохдоо хяналт хийж байгаа ч хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна. Түүнээс гадна санхүүжилтийн эх үүсвэрийг журмын 2 дугаар хавсралтдаа ихэвчлэн тусгаж оруулж байгаа нь журмын 52.5-д заасан шаардлагыг биелүүлэхгүй байна.

Иймд хуулийн 6 дугаар зүйлд заасан бодлогын баримт бичгийн төрөл тус бүрт санхүүжилт, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байна гэж заасныг ХБББНЖ-д нэг

³⁰ Төрийн захиргааны төв байгууллага нь төрөөс баримтлах бодлогын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авна. Санал авахаар бодлогын баримт бичгийг хүргүүлэхдээ дараах мэдээллийг хавсаргасан байна:

³¹ Төрийн захиргааны төв байгууллага нь төрөөс баримтлах бодлогын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авна. Санал авахаар бодлогын баримт бичгийг хүргүүлэхдээ дараах мэдээллийг хавсаргасан байна:

бүрчлэн тодорхойлох мөн батлагдсан хувилбар нь ямар шаардлага хангасан байх тухай зааж өгөх шаардлагатай байна.

1.5 Журамд заасан боловсруулалтын шатны шаардлагыг хангаагүй байхад зөвшөөрөл олгож байна.

ХБТТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.2-т бодлогын баримт бичгийн төсөл нь урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцэж байгаа эсэх, түүнд тусгагдсан төсөв, санхүүгийн тооцоолол, санхүүжилтийн эх үүсвэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянахаар заасан байхад ХБББНЖ-ын 31, 32, 33-т уг нөхцөлүүдийг тусгалгүй зөвхөн дагалдах хавсралтуудыг шаардсан байна.

Өөрөөр хэлбэл хуульд зааснаар төслийн үндсэн баримт бичгийг шалгах байтал журмаар баталсан холбогдох хавсралтуудыг шалгаж, хүлээж авч байна.

Мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т *“Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсруулах ажлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулна”* гэж 2016 оны 7 дугаар сард хуульд өөрчлөлт оруулсан.

Гэтэл ХБББНЖ-ын 32-т *“Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт энэ журмын 31.1-31.7-д заасан мэдээллийн хамт хүргүүлнэ”* гэж заасан байгаа нь ҮХГ болон Сангийн яам хоёрын хооронд ямар зохицуулалт хийгдэхийг тодорхойгүй болгож хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж журамд өөрчлөлт оруулаагүй байна.

ХБТТХ, ТТХ, ХБББНЖ, ББХБЗБҮАХШҮХНЖ-д заасан зохицуулалтаар хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн боловсруулах, хэлэлцүүлэх зөвшөөрөл олгох, батлах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл явцад нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг нь ЗГ, ЗГХЭГ, СЯ, Үндэсний хөгжлийн газар гэсэн 4 үндсэн субъектэд хуваагдсан байна. Оролцогч талуудын чиг үүрэг, хууль болон журмын зохицуулалтыг хавсралт №10-аар харуулав.

Хууль батлагдсанаас хойш гарсан бодлогын баримт бичгүүд боловсруулахад шаардагдах журмын заалтуудыг биелүүлээгүй байхад эрх бүхий этгээдүүд зөвхөн журмын 31-д заасан 6 хавсралт материалаар зөвшөөрөл өгч баталж байна.

Иймд баримт бичгийн төсөлд тавигдах журмын бусад шаардлагыг хянаж, шаардлага хангасан тохиолдолд зөвшөөрөл өгч баталж байх заалтыг хууль, журамд нэмж оруулах шаардлагатай байна.

1.6 Журамд заасан шаардлагуудад нийцүүлэн санал авч, хянан боловсруулах шаардлагатай байна.

ХБТТХ-ийн 7.3, 8.3, 9.3, 10.3, 12.3, 12.6, 13.5, 14.5, ХБББНЖ-ын 31.4-т заасны дагуу захиргааны байгууллага нь бодлогын баримт бичгийн төсөлд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, олон нийтийн оролцоог хангаж хэлэлцүүлгийн явцад гарсан саналуудыг багцалсан товъёог баримт бичгийн хавсралт болгож эрх бүхий байгууллагад хүргүүлж байна.

Аудитын явцад саналуудын багцалсан товъёогоос үзэхэд нь хэт ерөнхий, ач холбогдолгүй, хүрэх үр дүн тодорхойгүй арга хэмжээг нэмэгдүүлсэн байгаа нь

бодлогын баримт бичгийн төслийг ХБББНЖ-ын 54, 55, 56, 57, 58-д заасан шаардлагад нийцүүлэн боловсруулаагүйтэй холбоотой байна. Тухайлбал:

Хуулийн 10 дугаар зүйлд заасан “Үндэсний хөтөлбөр”-т хамрагдах ЗГ-ын 2017 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан ХНХЯ-ны “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийн хэлэлцүүлгийн саналын багц товъёогоос жишээ авч үзвэл:

Хүснэгт №5

Хөтөлбөрийн зорилт	Санал өгсөн байгууллага, хувь хүн	Нэмэлт оруулах санал	Тусгасан эсэх	Дүгнэлт
<u>Зорилго 1.</u> Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгахад чиглэсэн цогц арга хэмжээгээр жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг дэмжиж нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг сайжруулна.	Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэг, ХНХЯ-ны ЖСЗ, Баян-Өлгий, Увс, Ховд, Сэлэнгэ, Булган аймгуудын ЖСХ	-ЖЭТБХТХ-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх -Олон нийтийн хандлагыг өөрчлөх цогц арга хэмжээ хэрэгжүүлэх -Хүйсийн ялгаварлан гадуурхалт, алагчлах үзлийг устгах -Нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг сайжруулах	Саналыг нэгтгэн тусгаж шинэчлэн томъёолсон.	Ямар шалгуур үзүүлэлтүүдээр хэмжих нь тодорхойгүй, шалгуур үзүүлэлтүүдийн суурь үзүүлэлт, зорилтод түвшин нь батлагдаагүй, хэрхэн сайжрах нь тодорхойгүй байна.

Эх сурвалж: Баримт бичгийн төслийн хавсралт №3-ын 1 дүгээр хуудас

Хэт ерөнхий, ач холбогдолгүй, хүрэх үр дүн тодорхойгүй санал авч байгаа нь боловсруулагдаж байгаа бодлогын бүх баримт бичигт гарч байгаа нийтлэг алдаа тул журмын дээрх шаардлагуудад нийцүүлэн саналыг хянан боловсруулах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТЫГ ХҮРЭХ ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР НЬ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

2.1. Зарим бодлогын баримт бичигт 2017 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ үнэлгээ хийж холбогдох байгууллагад тайлагнасан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиар хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх хугацааг дараах байдлаар зааж өгсөн байна. Үүнд:

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хуулийн заалт, хугацаа

Хүснэгт №6

Бодлогын баримт бичгийн төрөл	Хэрэгжүүлэгч байгууллага	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хуулийн заалт, хугацаа	Хөндлөнгийн үнэлгээ
Хөгжлийн үзэл баримтлал	Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлаар хариуцна. /хуулийн 7.5/	Төрийн захиргааны төв байгууллага 2 жил тутамд, СЯ нэгдсэн тайланг ЗГ-т хүргүүлнэ. /хуулийн 7.5, 7.6 ХШҮ-ны журмын 7.5.1/	Сангийн яам 4 жил тутамд зохион байгуулна. /хуулийн 7.7, ХШҮ-ны журмын 7.5.1/
Төрөөс баримтлах бодлого	Төрийн захиргааны төв байгууллага /хуулийн 8.5/	Төрийн захиргааны төв байгууллага 2 жил тутамд /хуулийн 8.6, ХШҮ-ны журмын 7.5.2/	Төрийн захиргааны төв байгууллага 4 жил тутамд зохион байгуулна. /хуулийн 8.6, ХШҮ-ны журмын 7.5.2/
Бүсчилсэн хөгжлийн бодлого	Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны бүх байгууллага	Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага 2 жил тутамд /хуулийн 13.6, ХШҮ-ны журмын 7.5.7/ ҮХГ үр дүнг нэгтгэн ЗГ-т танилцуулна.	Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага 4 жил тутамд зохион байгуулж ҮХГ үр дүнг нэгтгэн ЗГ-т танилцуулна. /хуулийн 13.6, ХШҮ-ны журмын 7.5.7/
Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	Засгийн газар	Төрийн захиргааны төв байгууллага хийж ЗГХЭГ нэгтгэнэ /хуулийн 9.4, ХШҮ-ны журмын 7.5.3, МУИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.1/	Төрийн захиргааны төв байгууллага хийж ЗГХЭГ нэгтгэнэ /хуулийн 9.5, ХШҮ-ны журмын 7.5.3 /хугацаа тодорхойгүй./
Үндэсний хөтөлбөр	Төрийн захиргааны төв байгууллага /хуулийн 10.6/	Төрийн захиргааны төв байгууллага жил бүр /хуулийн 10.7, ХШҮ-ны журмын 7.5.4/	Төрийн захиргааны төв байгууллага шаардлагатай бол зохион байгуулна. /хуулийн 10.7/ хугацаа тодорхойгүй
Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр	Үндэсний хөгжлийн газар	ҮХГ 2 жил тутамд /хуулийн 11.4, ХШҮ-ны журмын 7.5.5/	Зохицуулалт байхгүй
Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	Төрийн захиргааны төв байгууллага	Сангийн яам жил бүр /ХШҮ-ний журмын 7.5.6/	Зохицуулалт байхгүй

Мөн хяналт-шинжилгээ үнэлгээг хэрхэн хийх талаар ХББББНЖ-ын 66-69, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-аар нарийвчлан зохицуулж өгсөн байна.

ХБТТХ хэрэгжиж эхэлснээс хойш батлагдсан бодлогын баримт бичгүүдээс хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хуулийн хугацаа болсон 11 баримт бичиг байгааг хүснэгтээр харуулав.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хуулийн хугацаа болсон баримт бичиг

Хүснэгт №7

№	Бодлогын баримт бичгийн нэр	Баталсан шийдвэр, огноо	Хүчинтэй хугацаа	Хэрэгжүүлэгч байгууллага
---	-----------------------------	-------------------------	------------------	--------------------------

1	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр	ЗГ-ын 2016 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 233 дугаар тогтоол	2016-2020	ШӨХТГ
2	Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр	УИХ-ын 2016 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн 287 дугаар тогтоол	2016-2023	АТГ
3	Сав, баглаа боодол үндэсний хөтөлбөр	ЗГ-ын 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 287 дугаар тогтоол	2017-2021	ХХААХҮЯ
4	Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр	ЗГ-ын 2016 оны 2 дугаар сарын 4-ны өдрийн 16 дугаар тогтоол	2016-2020	ХНХЯ
5	Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	ЗГ-ын 2016 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 304 дугаар тогтоол	2016-2021	ХНХЯ
6	Эдийн засгийг сэргээх хөтөлбөр	УИХ-ын 2016 оны 11 дүгээр сарын 24 өдрийн 71 дүгээр тогтоол	2017-2018	СЯ
7	Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөр	ЗГ-ын 2016 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 233 дугаар тогтоол	2016-2019	ГХЯ
8	Дэлхийн монголчууд үндэсний хөтөлбөр	ЗГ-ын 2016 оны 1 дүгээр сарын 4-ны өдрийн 1 дүгээр тогтоол	2016-2020	ГХЯ
9	Монгол улсыг гадаадад сурталчлах үндэсний хөтөлбөр	ЗГ-ын 2016 оны 1 дүгээр сарын 4-ны өдрийн 2 дугаар тогтоол	2016-2020	ГХЯ
10	Орлоготой оюутан үндэсний хөтөлбөр	ЗГ-ын 2016 оны 12 дугаар сарын 4-ны өдрийн 2 дугаар тогтоол	2016-2020	БСШУЯ
11	МУ-ын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	УИХ-ын 2016 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн 70 дугаар тогтоол	2017	СЯ

Дээрх бодлогын баримт бичгийн хяналт шинжилгээ хийсэн үнэлгээний тайланг авч үзвэл ББХЗБҮАХШҮХНЖ-ын 6.4-т зааснаар бодлогын зорилт, хэрэгжилтийн ерөнхий дүнг үнэлэх арга зүйг зааж өгсөн боловч ХБТТХ-д хамаарагдах бодлогын баримт бичгүүдэд зорилго, зорилт, арга хэмжээ тус бүрээр гүйцэтгэлийн үр дүнг зорилтод түвшинтэй харьцуулан хувиар илэрхийлэх боломжгүй байна.

Учир нь тухайн бодлогын баримт бичигт зорилго, зорилтыг арга хэмжээ тус бүрээр нь ямар шалгуур үзүүлэлтээр хэмжих нь тодорхойгүй, шалгуур үзүүлэлтүүдийн суурь он, суурь үзүүлэлт, зорилтод түвшинг батлаагүй байна. Тухайлбал:

ЗГ-ын 2016 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэсэн байдлыг авч үзвэл:

Хүснэгт №8

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага	Биелэлт	Тайлбар
1	Монгол Улсын түүх, соёлын уламжлал, эдийн засаг, нийгмийн салбарын ололт амжилтыг гадаадад сурталчлах үйл ажиллагааг	2016	ГХЯ, БСШУЯ	“УИХ-ын ээлжит 7 дахь удаагийн сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан МУ-ын ЗГ-ын бүтэц дэх 10 яаманд Гадаад сурталчилгаа, хамтын ажиллагааны асуудал хариуцсан хэлтэс байгуулагдан үйл ажиллагаа	Ямар шалгуур үзүүлэлтүүдээр хэмжих нь тодорхойгүй, шалгуур үзүүлэлтүүдийн суурь он, суурь үзүүлэлт, зорилтод

идэвхжүүлэх, гадаад сурталчилгааны бүтэц бий болгохыг дэмжих		явуулж байна. 3 яаманд уг асуудлыг холбогдох газрууд хавсран хариуцаж байна. ГХЯ-наас яамд болон НЗДТГ-ын гадаад хамтын ажиллагааны асуудал хариуцсан газрын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, МУ-ыг гадаадад сурталчлах бодлого, стратеги болон яамдын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.” Биелэлт 50 хувь гэсэн байна.	түвшин нь батлагдаагүй, арга хэмжээ нь гүйцэтгэлийн үр дүнг зорилтод түвшинтэй харьцуулж хувиар илэрхийлэх боломжгүй байхад юуг үндэслэж, 50 хувиар үнэлсэн нь тодорхойгүй байна.
--	--	--	--

Мөн ББХЗБҮАХШҮХНЖ-ын 6.2-т зааснаар бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг 0-100 хувиар дүгнэх аргачлал гаргасан боловч дээрх нөхцөл байдлаас үүдэн зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрсэн эсэхийг хэмжих боломжгүй байдал үүсч байна.

Өөрөөр хэлбэл ХБББНЖ-ийн 54.1³², 54.2³³, 58-д заасан шаардлагыг хангаагүй учир хяналт-шинжилгээ үнэлгээг ХБББНЖ-ын 66-69, ББХЗБҮАХШҮХНЖ-ын дагуу үнэлгээ хийсэн нь бодитой биш байна.

Аймгийг хөгжүүлэх хэтийн зорилт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад 2 жил тутам хяналт-шинжилгээ үнэлгээ, 4 жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийхийг ХБТТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.6, 15 дугаар зүйлийн 15.7-д заасан бөгөөд хөгжлийн бодлогын баримт бичгийг баталснаас хойш 2 жил болоогүй тул аймгийн ЗДТГ-аас хяналт үнэлгээ хийх хугацаа болоогүй байна.

Иймд бодлогын баримт бичгийг боловсруулалтын шатнаас эхлэн бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлтийг бусад бодлогын баримт бичиг, статистикийн мэдээ, салбарын мэдээлэлд үндэслэн бодитой, хэмжиж болохуйц боловсруулах шаардлагатай байна.

2.2. ХБББНЖ-д заасан боловсруулалтын шатны шаардлагыг хангаагүйгээс хяналт-шинжилгээ үнэлгээг ББХЗБҮАХШҮХНЖ-ын дагуу үнэлж байгаа нь бодитой биш байна.

Бодлогын баримт бичгүүд боловсруулахад шаардагдах журмын заалтуудыг биелүүлээгүй байхад эрх бүхий этгээдүүд зөвхөн журмын 31-д заасан хавсралт материалаар зөвшөөрөл өгч баталж байгаа нь ББХЗБҮАХШҮХНЖ-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хүндрэлтэй байдал үүсч байна.

Өөрөөр хэлбэл шинээр батлагдаж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгүүд бүхэлдээ ХБТТХ-ийн 17 дугаар зүйл болон журамд тавигдсан хэлбэрийн шаардлагыг хангасан боловч тэдгээрийн чанарын шаардлагыг дүгнэж үзвэл хангалтгүй³⁴ үнэлгээтэй байна .

³² Бодлогын зорилго, зорилт нь тухайн бодлогыг хэрэгжүүлснээр урт, дунд хугацаанд нийгэм, эдийн засгийн хөгжилд бий болохоор хүлээгдэж байгаа өөрчлөлтийг илэрхийлсэн бодлогын үр нөлөөнд тулгуурласан тодорхой, хэмжиж болохуйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц бодитой байна;

³³ Бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хугацааг тодорхойлсон байна;

³⁴ Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.3.3-т зааснаар 10-49 хувь байвал хэрэгжилт хангалтгүй гэж үзнэ.

ХБТТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.3³⁵, 6.4.3³⁶-т хамаарагдах баримт бичгийн төслийн бүтэц, агуулгыг ХБББНЖ-ын 52.6-д “*бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ үнэлгээний төлөвлөгөө*”-тэй байхаар заасан байна.

Энэ нь хөгжлийн бодлого хэрэгжилтийг оновчтой удирдах чухал арга хэрэгсэл болох ч аудитад хамрагдсан хөгжлийн бодлогын баримт бичгээс нэг нь ч энэ шаардлагыг хангаагүй, хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулан ажиллаагүй байна.

2.3 Ихэнх бодлогын баримт бичгийн хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, тайлагнах хугацаа болоогүй байна.

ХБТТХ, ТТХ, ХБББНЖ, ББХБЗБҮАХШҮХНЖ-д заасан зохицуулалтаар хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг нэгтгэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл явцад нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг нь ЗГ, ЗГХЭГ, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар болон орон нутагт нутгийн захиргааны байгууллагууд хэрэгжүүлэхээр заасан байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4-т хамаарах баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хуулийн хугацаа болоогүй байна.

Нутгийн захиргааны байгууллага буюу ЗДТГ-ын дэргэдэх ХШҮДАХ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөр, аймаг хөгжүүлэх хэтийн зорилт зэрэг баримт бичгүүдийн хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, тайланг ИТХ-д танилцуулан тухайн оны 02 дугаар сарын 20-ны дотор ЗГХЭГ-т хүргүүлэх хуулийн хугацаа болоогүй 2018 онд үнэлгээ хийж хүргүүлэхээр байна.

Сумдад хөгжлийн бодлогын хэрэгжилтийн тайланг нэгтгэн тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг ихэвчлэн 1-2 мэргэжилтэн үндсэн ажлаас гадна давхар гүйцэтгэж байгаа нь чанарт нөлөөлж байна.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэх, үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих үүрэг бүхий байгууллага болон албан тушаалтнууд хуульд заасан үүргээ хэрэгжүүлж байгаа хэдий ч дараах нийтлэг зөрчлүүд байна. Тухайлбал:

- Дундговь аймгийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөний 4 дүгээр бүлэгт зааснаар 2016 оны эхний улиралд төлөвлөгөөний хэрэгжилтийн үе шатны хяналт, үнэлгээ хийгдэх байсан боловч хийгдээгүй байна. Энэ нь төлөвлөлт, хяналтын хороо стратеги төлөвлөгөөг хэрэгжиж эхэлснээс хойш жил бүр төлөвлөгөө гаргаагүй, хэрэгжилтийг тооцож, тайлагнаагүй, ХОХБТХ-ээс төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавиагүйгээс шалтгаалсан байна.
- Аймаг, нийслэлийн ИТХ-аар баталсан 2016 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хүргүүлээгүй байна. Энэ нь ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “*Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам*”³⁷-д ЗГХЭГ-т хүргүүлэх тайлангийн жагсаалтад эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт байхгүй гэсэн заалт нь ХБТТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.5³⁸ дахь заалттай зөрчилдөж байсантай холбоотой байна.
- Баян-Өлгий аймгийн ЗДТГ-ын дэргэдэх ХШҮДАХ нь Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Аймгийн 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг тооцож гаргасан боловч ИТХ-аар хэлэлцүүлж, дүгнүүлээгүй нь ХБТТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.7, 16 дугаар зүйлийн 16.5 дахь заалтыг зөрчсөн байна.

³⁵ Дунд хугацааны буюу 8-10 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын дараах баримт бичиг байна:

³⁶ үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөр;

³⁷ ББХБЗБҮАХШҮХНЖ батлагдахаас өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан.

³⁸ Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 02 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ

- Сэлэнгэ аймгийн сумдын Засаг дарга нарын мөрийн хөтөлбөр болон дэд хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хууль, журамд заасан хугацаанд аймгийн ЗДТГ-ын дэргэдэх ХШҮДАХ-д хүргүүлсэн боловч улс төрийн тогтворгүй нөхцөл байдал болон орон нутгийн сонгуультай холбоотойгоор 2016 онд биелэлтийг тооцон хянаж, үнэлэлт, дүгнэлт өгөөгүй нь ХБТТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.7, 16 дугаар зүйлийн 16.5 дахь заалтыг зөрчсөн байна.
- Хэнтий аймгийг хөгжүүлэх хэтийн зорилтын үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг 2015 онтой харьцуулан 2020, 2030 онд хүрэх түвшинг тогтоосон ч хуульд заасны дагуу 2 жил тутамд явцад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээнд ямар шалгуур баримтлах нь тодорхойгүй байна.
- Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэл, дэд хөтөлбөрүүдийг батлахдаа Засгийн газрын 2016 оны 249 тоот тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 52.6, 61.6-д заасны дагуу бодлогын бичгийн хэрэгжилтийг ямар хугацаанд тайлагнахыг заагаагүй байна.
- Мөн шат шатны ИТХ ХБТТХ-ийн 15.8-д заасны дагуу үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажил зохион байгуулаагүй байна.
- Засаг дарга өөрчилдөг нь сумдад хэрэгжиж буй хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, үр дүн, үр нөлөө бодитой тайлагнагдахгүй, үнэн зөв үнэлэгдэхгүй байх эрсдэлийг дагуулж байна.

Төлөвлөсөн зорилтод түвшинд хүрсэн эсэхийг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх үйл ажиллагаа учраас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ журамд заасны дагуу шалгуур үзүүлэлт тус бүрээр суурь он, суурь үзүүлэлт, зорилтот түвшин болон оныг тус тус тодорхойлсон тохиолдолд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжтой болно.

Гэтэл бодит байдалд бодлогын баримт бичиг боловсруулж батлуулахдаа уг шаардлагыг биелүүлэхгүй байгаа нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх эрх бүхий байгууллагуудад явцын болон эцсийн, мөн хөндлөнгийн үнэлгээ хийхэд хүндрэл учруулж, субъектив шинж чанартай арга зүйгээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хүргэж байна.

Өөрөөр хэлбэл баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтийг ашиглахгүйгээр зөвхөн тухайн зорилтын хүрээнд хийхээр төлөвлөсөн ажлын үзүүлэлтийг хийсэн ажлын үзүүлэлттэй харьцуулж баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна.

БҮЛЭГ 3. ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ ҮҮСГЭЖ, ЭРХЛЭН ХӨТЛӨХ ЖУРМЫГ БОЛОВСРУУЛЖ ГАРГААГҮЙ БАЙНА.

3.1 Бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг тухайн асуудал хариуцсан захиргааны байгууллага хариуцан зохион байгуулж байна.

ХБТТХ-ийн 22 дугаар зүйлд Хөгжлийн бодлогын баримт бичгийг төрийн захиргааны төв байгууллагууд тухайн салбарын бодлогын залгамж чанарыг хадгалах зорилгоор өмнө хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг нэгтгэсэн эмхэтгэлийг жил бүр олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, хэвлэн нийтлэх чиг үүргийг зохицуулж өгсөн байна.

Хуулийн 22 дугаар зүйлийн 22.3³⁹, 22.4⁴⁰-д заасны дагуу Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бодлогыг уялдуулан зохицуулах, хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эмхэтгэлийг боловсруулж, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, журмыг баталж гаргах чиг үүргийг хүлээсэн боловч хэрэгжилт хангалтгүй мөн хуулинд чиг үүргийн давхардал байгааг арилгах шаардлагатай байна.

Үндэсний хөгжлийн газар нь Азийн хөгжлийн банктэй хамтран хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх төлөвлөгөөтэй байгаа ч төсөл хэлбэрээр яригдаж байгаа, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, журмыг баталж гаргаагүйгээс захиргааны байгууллагуудын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

Мөн Монгол Улсын их хурал болон Засгийн газраас баталсан үндэсний хэмжээний болон салбарын, салбар дундын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг ХБТТХ болон хөгжлийн үзэл баримтлалд уялдуулан, хуулийн ангилалд хамааралгүй баримт бичгийг цэгцлэхээр гаргасан УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол хугацаандаа хэрэгжээгүй байна.

Батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, хэвлэх сурталчлах ажлыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулж байна.

3.2 Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хууль, журамд заасан үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна.

ХБТТХ-ийн 7-16 дугаар зүйлд тодорхойлж өгсөн бодлогын баримт бичгүүдэд хэрхэн төлөвлөх, боловсруулах, батлах, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ өгөх асуудлыг тус тусд нь зохицуулж өгсөн ч дээрх үе шатууд нь хуулийн дагуу явагдаж байгааг нэгдсэн удирдлагаар хангах, түүнийг хариуцах байгууллага байх талаар тус хуулинд тусгаагүй байна.

Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /СЯ/ ХБТТХ-д 2016 оны 7 дугаар сарын 21-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулах

³⁹ 22.3.Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бодлогыг уялдуулан зохицуулах хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтөлнө.

⁴⁰ 22.4.Энэ хуулийн 22.2-т заасан эмхэтгэлийг боловсруулж, хэвлэн нийтлэх, 22.3-т заасан мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус батална.

хүртэл дангаараа 7 дугаар зүйлийн 7.5⁴¹, 7.6⁴², 7.7⁴³, 10 дугаар зүйлийн 10.3⁴⁴, 10.4⁴⁵, 11 дүгээр зүйлийн 11.4⁴⁶, 13 дугаар зүйлийн 13.2⁴⁷, 13.5⁴⁸, 12 дугаар зүйлийн 12.6⁴⁹, 17 дугаар зүйлийн 17.2⁵⁰, 22 дугаар зүйлийн 22.3⁵¹-22.5⁵²-д заасан чиг үүргийг мөн боловсруулалтын шатанд нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангахаар зохицуулагдсан байсан.

Гэвч хуульд дээрх нэмэлт, өөрчлөлт оруулснаар ҮХГ тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4-т заасан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт зөвхөн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр, 13 дугаар зүйлийн 13.2, 13.5-д зааснаар бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичгийн боловсруулалт болон батлуулах хүртэлх процессыг, 22 дугаар зүйлийн 22.3-22.5 зааснаар зөвхөн бодлогын баримт бичгийг боловсруулахад нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөхөд холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг хэрэгжүүлэхээр өөрчлөлт орсон ч батлагдсан бодлогын баримт бичгийг нэгдсэн удирдлагаар хангах, түүнийг хариуцах байгууллагын талаар тус хуулинд зохицуулагдаагүй хэвээр байна.

Харин Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт *“Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөр, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсвийн биелэлтийг хангах ажлыг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан зохион байгуулна”* гэж заасан ч хэрэгжилт хангалтгүй байна.

Үндэсний хөгжлийн газар нь ХБТТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.3-д заасны дагуу Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах чиг үүрэг хүлээсэн боловч аудитын явцад дээрх хөтөлбөрийн боловсруулалтын шатны холбогдох баримт материал ирүүлсэн ч хууль, журмын шаардлага хангаж боловсруулаагүй, мөн тус

⁴¹ 7.5.Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

⁴² 7.6.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 7.5-д заасан тайланг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

⁴³ 7.7.Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтэд дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

⁴⁴10.3.Энэ хуулийн 10.2-т заасан жагсаалтад орсон үндэсний хөтөлбөрийг төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд боловсруулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна.

⁴⁵ 10.4.Салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн төслийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна.

⁴⁶ 11.4.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн гүйцэтгэлд үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

⁴⁷ 13.2.Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсруулах ажлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулна.

⁴⁸ 13.5.Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналд үндэслэн бүсчилсэн хөгжлийн бодлогын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна.

⁴⁹ 12.6.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах саналыг хүлээн авч нэгтгэн, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулан боловсруулж, жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор Засгийн газарт хүргүүлнэ.

⁵⁰ 17.2.Төрийн захиргааны төв байгууллагын боловсруулсан хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл нь урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцэж байгаа эсэх, түүнд тусгагдсан төсөв, санхүүгийн тооцоолол, санхүүжилтийн эх үүсвэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгоно.

⁵¹ 22.3.Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бодлогыг уялдуулан зохицуулах хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтөлнө.

⁵² 22.4.Энэ хуулийн 22.2-т заасан эмхэтгэлийг боловсруулж, хэвлэн нийтлэх, 22.3-т заасан мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтөлж журмыг үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус батална.

22.5.Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөгжлийн бодлого төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлох, хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулахад нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, чадавхыг бэхжүүлэхэд холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д заасны дагуу бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг 2016 онд багтааж боловсруулж гаргаагүй байна. УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолд заасан боловч ажлын хэсэг байгуулагдан ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулах шатандаа явж байна.

Мөн ҮХГ нь ХБТТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5-д заасан чиг үүргээ биелүүлээгүй, ХБББНЖ-ын 54, 55, 56, 57, 58-д заасан шаардлагуудыг боловсруулалтын шатанд хэрхэн хэрэгжүүлэх талаар нэгдсэн удирдлагаар хангаж, арга зүйн талаас нь зөвлөгөө өгч ажиллаагүй байна.

Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд /4 жилийн/ урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн боловсруулалт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний явцыг нэгдсэн удирдлагаар хангах тогтолцоо бий болох, түүнийг урт хугацаагаар оршин тогтох нөхцөл бүрдүүлж чадахгүй байна.

Мөн ХБТТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.2.3, 7.3, 7.8-д заасны дагуу Засгийн газар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг УИХ-аас өгсөн чиглэлийн дагуу удирдамж гаргаж боловсруулахаар мөн хөндлөнгийн үнэлгээний тайланг УИХ-д танилцуулах чиг үүргийг хэрэгжүүлэхээр зааж өгсөн, хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-7.8-д зааснаар СЯ хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг нэгтгэн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх мөн хөндлөнгийн үнэлгээ хийх асуудлыг хариуцан зохион байгуулахаар тус тус заасан нь нэг бодлогын баримт бичгийн боловсруулалтын болон хяналт-шинжилгээний үе шатны ажлыг хоёр байгууллагад хуваарилсан ч удирдлагаар хангах чиг үүргээ сайжруулах хэрэгтэй байна.

ХБТТХ-д МУ-ын хөгжлийн үзэл баримтлалын тэргүүлэх чиглэлийг дунд хугацаанд салбарын болон салбар хоорондын түвшинд цогц байдлаар уялдуулан, хэрэгжүүлэхээр тусгасан боловч дараах баримт бичгүүд ХБББНЖ-ын 55-д заасан шаардлагыг хангаагүйгээс дор дурдсан хуулийн заалтууд хэрэгжихгүй байна. Тухайлбал:

-ХБТТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1-д Төрөөс баримтлах бодлого нь МУХҮБ –ын тэргүүлэх чиглэлийг дунд хугацаанд салбарын болон салбар хоорондын түвшинд цогц байдлаар хэрэгжүүлэхээр,
- 9.1, 4.1.6-д Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлогод суурилсан, Улсын Их Хурлын сонгуулиар олонх суудал авсан улс төрийн нам, улс төрийн намуудын эвслийн мөрийн хөтөлбөрийн хүрээнд боловсруулагдсан, хөгжлийн дунд хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон байхаар,
-10.1-д Үндэсний хөтөлбөрт төрөөс баримтлах бодлого, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээг нарийвчлан төлөвлөсөн байхаар,
-11.1-д Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байхаар,
-12.1-д Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөр болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээнд үндэслэн боловсруулахаар,
- 13.1, 4.1.3-д Бүсчилсэн хөгжлийн бодлого нь МУ-ын хөгжлийн үзэл баримтлалд суурилсан, бүс нутаг, хот байгуулалтын уялдаа, байгаль орчны тогтвортой байдлыг хангах замаар орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон байхаар,
-14.1-д .Засаг дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өгсөн чиглэлийн дагуу аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулахаар,
-15.1-д Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь бүсчилсэн хөгжлийн бодлого, аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилттой уялдсан байх ба тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн дунд хугацааны эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын чиглэл, түүнд хүрэх зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, төсөв, санхүүгийн эх үүсвэр, шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байхаар,
-16.1-д Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрт үндэслэн тухайн жилд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх

чиглэлээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тодорхойлсон байхаар.

ХБТТХ-ийн 13 дугаар зүйлд тодорхойлсон Бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичгийг 13.2-т заасны дагуу үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулахаар, 13.3-т МУХҮБ, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай, Хот байгуулалтын тухай хуультай уялдуулан боловсруулж ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах чиг үүргийг зааж өгсөн байна.

Гэтэл бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д Засгийн газар бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах чиг үүрэгтэй байхаар зааж өгсөн ч хэрэгжилт хангалтгүй Бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсруулах ажлын хэсэг байгуулан ажил нь эхлэлийн шатандаа явагдаж байна.

ХБББНЖ-ын ХБТТХ-ийн 6.3, 6.4.3-т заасан дунд хугацааны баримт бичгүүдэд төлөвлөгөө боловсруулахдаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байгууллага, нэгтгэн тайлагнах хугацаа, түүний үр дүн санал зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг тусгасан байхыг шаардсан боловч бусад бодлогын баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар нарийвчилсан тодорхой зохицуулалт оруулаагүй байна. Энэ нь холбогдох баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ журмын 57, 58-д заасан арга зүйг ашиглан хийх боломж олгохгүй байна.

ХБТТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1-д Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалыг хангахад чиглэсэн зорилго, зорилт, хүрэх үр дүнг нөөц, эх үүсвэртэй нь уялдуулан тооцсон хөгжлийн загварт суурилсан байна гэж заасан боловч ХБТТХ-ийн 6 дугаар зүйлд заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төрөлд *“Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал”*-ыг оруулаагүй байна.

ХБББНЖ-ын 54, 55, 56, 57, 58-д заасан шаардлагуудыг боловсруулалтын шатанд хэрэгжүүлээгүй байхад ХБТТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.2, ХБББНЖ-ын 31-д зааснаар СЯ төрөөс баримтлах бодлогын төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл олгохдоо зохих хяналтыг хийж байгаа ч зөвхөн журмын 6 хавсралтыг бөглөсөн эсэхийг шалгаж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж байна.

Ингэснээр бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдаа хангагдаагүй, бодлогын үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтүүд нь тодорхойгүй баримт бичгүүд батлагдаж байгааг өөрчлөх шаардлага гарч байна. /Хавсралт №11/

Иймд СЯ болон ҮХГ нь холбогдох журмын заалтуудыг нэг бүрчлэн шалган мөрддөж ажиллах хэрэгтэй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

- Монгол Улсын их хурал болон Засгийн газраас баталсан үндэсний хэмжээний болон салбарын, салбар дундын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг ХБТТХ болон хөгжлийн үзэл баримтлалд уялдуулан, хуулийн ангилалд хамааралгүй баримт бичгийг цэгцлэхээр гаргасан УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол биелэгдээгүй байна;
- Хуульд заасны дагуу Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бодлогыг уялдуулан зохицуулах, хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эмхэтгэлийг боловсруулж, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, журмыг баталж гаргах чиг үүргийг хүлээсэн боловч хэрэгжилт хангалтгүй байна;
- СЯ хууль батлагдсанаас хойш гарсан бодлогын баримт бичгүүд боловсруулахад шаардагдах журмын заалтуудыг биелүүлээгүй байхад зөвхөн журмын 31-д заасан 6 хавсралт материалаар зөвшөөрөл өгч баталж байна;
- Нөхцөл байдлын шинжилгээг хийхдээ тулгамдсан асуудлын мөн чанар, шалтгаан хүчин зүйлсийн харилцан хамаарлыг тодорхойлолгүй ерөнхий нөхцөл байдлын төлөвийг тоочин тодорхойлж байгаа нь хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хэт ерөнхий тодорхойлох, арга хэрэгслийг оновчгүй сонгох нөхцөл болж байна;
- ХБТТХ батлагдсанаас хойших бодлогын баримт бичгүүдэд бодлогын олон хувилбар боловсруулалгүй зөвхөн нэг хувилбарыг тодорхойлж түүндээ нэмэлт өөрчлөлт хийх замаар гаргаж байна;
- Журмын 9.13⁵³ дахь заалтыг тус журмын 18.4-т “*бодлогын хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийх*” гэж заасантай харьцуулахад логик дарааллын хувьд аль нь эхэлж хийгдэх нь тодорхойгүй, ойлголтын зөрүүтэй томъёолсон байна;
- Хуулийн 6 дугаар зүйлд заасан бодлогын баримт бичгийн төрөл тус бүрт санхүүжилт, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байхаар заасныг ХБББНЖ-д нэг бүрчлэн тодорхойлох шаардлагатай байна;
- ХБТТХ-ийг Төсвийн тухай хуультай уялдуулах ажлыг бүрэн хийгээгүйгээс хөгжлийн бодлогыг эрэмбэ, хугацаанаас үл хамааран санхүүгийн эх үүсвэрийг улс, орон нутгийн төсвөөс бусад олон эх үүсвэртэйгээр төлөвлөж болох зохицуулалттай хийсэн нь үндэсний хөтөлбөрийг төсвийн хуулинд тодорхойлсон хөтөлбөртэй уялдуулахгүй тодорхойлох, санхүүгийн нөөцийн бодит тооцоололгүй батлагдах нөхцөлийг бүрдүүлж байна;
- ХБББНЖ-ийн 54.1, 54.2, 58-д заасан боловсруулалтын шатны шаардлагыг хангаагүйгээс хяналт-шинжилгээ үнэлгээг ХБББНЖ-ын 66-69 болон ББХЗБҮАХШҮХНЖ-ын дагуу үнэлж байгаа нь бодитой биш байна;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулахдаа хууль, журамд заасан шаардлагуудыг хангаж боловсруулж батлуулаагүй байна.
- Бодлогын баримт бичиг боловсруулах хууль, журмын аргачлал, заавар боловсруулж, сургалт сурталчилгаа явуулах шаардлагатай байна.

⁵³ “Бодлогын хувилбар гэж нөхцөл байдлын дүн шинжилгээ болон нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд үндэслэн асуудлыг шийдвэрлэхээр санал болгосон бодлогын 2-оос дээш сонголтуудыг”

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдад:

1. Монгол Улсын их хурал болон Засгийн газраас баталсан үндэсний хэмжээний болон салбарын, салбар дундын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг ХБТТХ болон хөгжлийн үзэл баримтлалд уялдуулах, бодлогын баримт бичиг боловч хуульд заасан ангилалд хамаарахгүй баримт бичгийг цэгцэлж УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолын биелэлтийг хангуулах арга хэмжээ авах;
2. ХБТТХ-ийг дагаж гарсан ХБББНЖ, ББХБЗБҮАХШҮХНЖ-ын хуулиас ангид нэр томъёо, түүн дэх хоёрдмол ойлголт, тодорхой бус байдлыг тайланд дурдсаны дагуу залруулах арга хэмжээ авах;

Сангийн сайдад:

1. ХБТТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.2, ХБББНЖ-ын 31-д заасан бодлогын баримт бичгийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл олгохдоо холбогдох журмын заалтуудыг нэг бүрчлэн шалгаж мөрддөг байх;

Үндэсний хөгжлийн газрын даргад:

1. ХБТТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.3 , 22.4-д заасны дагуу Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бодлогыг уялдуулан зохицуулах, хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтлөх, эмхтгэлийг боловсруулж, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг боловсруулж, баталж гаргах чиг үүргээ хэрэгжүүлэх;
2. Хуулийн 22 дугаар зүйлийн 22.5-д заасан хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулахад нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, чадавхыг бэхжүүлэхэд холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлэх чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах;
3. Бодлогын баримт бичиг боловсруулах хууль, журмын аргачлал, заавар боловсруулж, сургалт сурталчилгаа явуулах.

Холбогдох байгууллагын санал:




МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР
 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
 Нөгдсөн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
 Утас/факс: (976-51) 26 33 33

2018.02.28 № 06/188
 танай _____ -ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
 НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
 БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
 АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
 ГҮЙЦЭТГЭГЧ Х.БОЛДБААТАР ТАНАА

Танай 2018 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 07/399 тоот албан бичгээр ирүүлсэн “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн аудитын тайлангийн төсөлд тус газраас зарчмын хувьд тусгайлан өгөх саналгүй болно.

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
 ХЭЛТЭСГИЙН ДАРГА Н.ОРХОН




МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ
 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
 С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
 Утас/факс: 26-74-68, http://www.mof.gov.mn

2018.02.28 № 5-2/961
 танай 2018.02.22-ны № 07/398-т

НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
 ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
 АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
 ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
 Х.БОЛДБААТАР ТАНАА

Танай байгууллагаас “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөл”-тэй танилцаад, саналаа хавсралтаар хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,

Хавсралт *Х* хуудас.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
 УДИРДЛАГЫН ГАЗРЫН
 ДАРГА Х.ЭНХБААТАР



Хавсралт

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД САНАЛ

Д/д	Агуулга	Санал
1.4	<p>Бүлэг 1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөж, боловсруулаагүй байна.</p> <p>Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн оновчтой хувилбарт үндэслэн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг ХБТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.1.4-т нарийвчлан төлөвлөж боловруулна гэж 8-10 жилийн дунд хугацааны заасныг ХББББНЖ-ын 52-т бодлого, үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөрийн бүтцийн шаардлагыг дэлгэрүүлэн тодорхойлсон боловч, тус журмын 61, 63-т заасан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн бүтэц, агуулгад тавигдах уг шаардлагыг орхигдуулсан байна.</p>	<p>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл нь Монгол Улсын Их Хурлын чуулгын хуралдааны дэгийн тухай хуулийн "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл, мөнгөний бодлого, төсөв, түүний гүйцэтгэлийг хэлэлцэх журам" буюу 4 дүгээр бүлэг, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 9 болон 12 дугаар зүйлээр зохицуулагдаж байгаа тул дахин авч үзэх;</p>
1.5	<p>Журамд заасан боловсруулалтын шаардлагыг хангаагүй байхад зөвшөөрөл олгож байна.</p> <p>ХБТТХ –ийн 17.2-т Төрийн захиргааны төв байгууллагын боловсруулсан хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл нь урт болон дунд хугацааны бодлогын бичигтэй нийцэж байгаа эсэх, түүнд тусгасан төсөв, санхүүгийн тооцоолол, санхүүжилтийн эх үүсвэрийг санхүү, төсвийн бодлогын баримт бичгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянан, зөвшөөрөл олгож байгаа тул дахин нягтлах;</p>	<p>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл нь Монгол Улсын Их Хурлын чуулгын хуралдааны дэгийн тухай хуулийн "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл, мөнгөний бодлого, төсөв, түүний гүйцэтгэлийг хэлэлцэх журам" буюу 4 дүгээр бүлэг, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 9 болон 12 дугаар зүйлээр зохицуулагдаж байгаа тул дахин авч үзэх;</p>

<p>төв байгууллага хянахаар заасан байхад ХББББНЖ-ын 31, 32, 33-т уг нөхцөлүүдийг тусгалгүй зөвхөн дагалдах хавсралтуудыг шаардсан байна.</p>	<p>Хууль батлагдсанаас хойш гарсан бодлогын баримт бичгүүд боловсруулахад шаардагдах журмын заалтуудыг биелүүлээгүй байхад эрх бүхий этгээдүүд зөвхөн журмын 31-д заасан 6 хавсралт материалаар зөвшөөрөл өгч баталж байна.</p>	<p>Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг болон ХББББНЖ-ын 31.1-31.7, 51-55 дахь заалтуудыг үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төрийн захиргааны төв байгууллагын боловсруулсан хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг олгож байна. Мөн ХББББНЖ-ын 34-т заасны дагуу хэрэв энэхүү журамд заасан бүрдэл материал дутуу тохиолдолд уг зарчим, шаардлага болон бүрдлийг хангуулах талаарх зөвлөмжийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлж ажиллаж байгаа тул дахин тодотгон авч үзэх;</p>
<p>Бүлэг 2. Бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтээр нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шаардлагатай байна.</p>	<p>Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх хуулийн хугацаа болсон баримт бичиг /үүснэгт 6/ Сав баглаа боодол үндэсний хөтөлбөр /ЗГ-ын 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 233 дугаар тогтоол/</p>	<p>Энэхүү хөтөлбөрийг Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 287 дугаар тогтоолоор баталсан тул тогтоолын дугаарыг засах;</p>
<p>2.1</p>	<p>Өөрөөр хэлбэл, баримт бичиг тусгагдсан шалгуур үзүүлэлтийг ашиглахгүйгээр өөр өөрсдийн тодорхойлсон арга зүйгээр баримт бичгийн шинжилгээ, үнэлгээг хийж байна.</p>	<p>Засгийн газрын 2016 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж байгаа тул дахин нягтлан авч үзэх;</p>
<p>2.3</p>		

Сангийн яамнаас ирүүлсэн саналд ҮАГ-аас өгөх тайлбар:

Санал нэг – Тайлбар үндэслэлгүй тул хүлээн авах боломжгүй.

Санал хоёр – Хэдийгээр Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь журмын 31.1-3.17-д заасны дагуу хянаж зөвшөөрөл олгож байгаа боловч журмын 51-55, 58-д заасан шаардлагад нийцүүлэн хянаж чадахгүй байгаа тул тайлбарыг хүлээн авах боломжгүй.

Санал гурав - Хүлээн авах боломжгүй.

Санал дөрөв - Хүлээн авч өөрчлөлтийг хийв.

Санал тав - Хүлээн авч өөрчлөлтийг хийв.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2018 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/41

Улаанбаатар хот

┌ Аудитын тайланг баталгаажуулах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан Нийцлийн аудитын түр журмын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд”-д хийсэн нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталсугай.
2. Аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий сайд болон Сангийн яам, Үндэсний хөгжлийн газарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2018 оны 12 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /У.Хүрэлсүх/, Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/, Үндэсний хөгжлийн газрын дарга /Б.Баярсайхан/ нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудиторт даалгасугай.
5. Аудитын тайланг батлагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор, энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч бөгөөд тэргүүлэх аудитор /С.Оюунбилэг/-т тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

Хавсралт №1. Аймаг, нийслэлийн бодлогын баримт бичгийн судалгаа

№	Баримт бичгийн төрөл	Хууль батлаг - дахаа с	Аймаг, нийслэлийн бодлогын баримт бичгийн судалгаа														Нийт								
			Архангай	Баян-Өлгий	Баянхонгор	Булган	Говь-алтай	Говьсүмбэр	Дархан-Уул	Дорноговь	Дорнод	Дундговь	Завхан	Орхон	Өвөрхангай	Өмнөговь		Сүхбаатар	Сэлэнгэ	Төв	Увс	Ховд	Хөвсгөл	Хэнтий	Нийслэл
Хуулийн 14 дүгээр зүйлд заасан:																									
1	Аймаг нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт /аймгийн хэмжээнд/	Өмнөх		10		1	1	1	1	1						1	1	1	1	16	14	1	4		52
		Хойнох	1		1	1					1									1			1	4	
2	Сум, дүүргийн түвшинд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх орон нутгийн онцлогийг тусгасан хөгжлийн дунд хугацааны бодлого /аймгийн хэмжээнд/	Өмнөх										12													13
		Хойнох		1																					
Хуулийн 15 дүгээр зүйлд заасан:																									
3	ЭД-ын мөрийн хөтөлбөр	Хойнох		20	14	17	1	4	4	15	15	14	16	3	21	16	14	1	27	16	18	23	19	10	30
		Хойнох	7	3	21	10	9	10	15	12		15	22	13	14	17		14	18	16			27	22	26
Хуулийн 16 дүгээр зүйлд заасан																									
4	Аймаг нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл /аймгийн хэмжээнд/	Хойнох	1	8	20	1	1	4	1	1	14	17	3	21	16	14	1	27	20	18	1	17	10	21	
																									7
Нийт			29	36	62	30	12	16	23	28	17	55	56	21	57	50	28	16	72	69	50	26	71	42	86
																									6

Хавсралт №2. Шинээр нэмэгдсэн бодлогын баримт бичгийн жагсаалт

№	Баримт бичгийн нэр	Баталсан субъект	Батлагдсан огноо	Яам, агентлагийн нэр	Боловсруулж дууссан эсэх	Бодлогын баримт бичгийн төрөл
1.	Барилгын салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого			Барилга, хот байгуулалтын яам	Боловсруулалтын шатандаа явж байгаа	Төрөөс баримтлах бодлого
2.	Төрөөс орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаар баримтлах бодлого			Барилга, хот байгуулалтын яам	Боловсруулалтын шатандаа явж байгаа	Төрөөс баримтлах бодлого
3.	Төрөөс газрын харилцаа, геодези, зураг зүйн талаар баримтлах бодлого			Барилга, хот байгуулалтын яам	Боловсруулалтын шатандаа явж байгаа	Төрөөс баримтлах бодлого
4.	Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлого			Барилга, хот байгуулалтын яам	Боловсруулалтын шатандаа явж байгаа	Төрөөс баримтлах бодлого
5.	Автотээврийн талаар төрөөс баримтлах бодлого			Зам, тээврийн хөгжлийн яам	Боловсруулалтын шатандаа явж байгаа	Төрөөс баримтлах бодлого
6.	Төрөөс авто замын талаар баримтлах бодлого			Зам, тээврийн хөгжлийн яам	Боловсруулалтын шатандаа явж байгаа	Төрөөс баримтлах бодлого
7.	Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр			Зам, тээврийн хөгжлийн яам	Боловсруулалтын шатандаа явж байгаа	Үндэсний хөтөлбөр
8.	Монгол Улсын Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр	ЗГ-299	10/3/2017	Сангийн яам	Батлагдсан	Үндэсний хөтөлбөр
9.	Газрын ховор элемент хөтөлбөр			Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Боловсруулалтын шатандаа явж байгаа	Үндэсний хөтөлбөр
10.	Үндэсний геомэдээллийн сан хөтөлбөр			Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Боловсруулалтын шатандаа явж байгаа	Үндэсний хөтөлбөр
11.	Монгол экспорт			Гадаад харилцааны яам	Боловсруулалтын шатандаа явж байгаа	Үндэсний хөтөлбөр
12.	Эрчим хүч хэмнэх хөтөлбөр	ЗГ-274	9/20/2017	Эрчим хүчний яам	Батлагдсан	Үндэсний хөтөлбөр
13.	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэл	УИХ-70	11/16/2017	Засгийн газар	Батлагдсан	ХБТТ хуульд хамаарахгүй БББ

Хавсралт №3. Батлагдсан болон батлагдаагүй нийт бодлогын баримт бичиг /Баталсан субъектээр/

Яам, агентлаг нэр	Батлагдсан	Нэмэлт өөрчлөлт хийгдсэн	Нэмэлт өөрчлөлт хийгдээгүй	Нэмэлт өөрчлөлт хийж байгаа	Шинээр боловсруулж байгаа	Нийт дүн
ЗГ	43		63	2		108
Агентлаг	5		12			17
Яам	38		51	2		91
УИХ	9	1	45	2		57
Агентлаг	4	1	15			20
Яам	5		30	2		37
Батлагдаагүй, боловсруулж байгаа					10	10
Яам					10	10
Grand Total	52	1	108	4	10	175

Хавсралт №4. Батлагдсан болон батлагдаагүй нийт бодлогын баримт бичиг /төрлөөр/

№	Баримт бичгийн нэр	Батлагдсан	Нэмэлт өөрчлөлт хийгдсэн	Нэмэлт өөрчлөлт хийгдээгүй	Нэмэлт өөрчлөлт хийж байгаа	Шинээр боловсруулж байгаа	Нийт дүн
1.	Хөгжлийн үзэл баримтлал	1					1
2.	Төрөөс баримтлах бодлого	6		21	2	6	35
3.	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал			1			1
4.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	1					1
5.	Үндэсний хөтөлбөр	27		35	2	4	68
6.	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр			1			1
7.	Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	2					2
8.	Дэд хөтөлбөр	1		1			2
9.	Хөтөлбөр ⁵⁴	8		11			19
10.	ХБТТ хуульд хамаарахгүй БББ	1	1	20			22
11.	Бодлогын баримт бичиг биш	5		18			23
12.	Grand Total	52	1	108	4	10	175

Хавсралт №5. ХБТТХ-д хамрагдахгүй баримт бичгийн тоо /яам, агентлаг, төрлөөр/

Баримт бичгийн нэр	Хууль батлагдахаас өмнөх	Хууль батлагдсанаас хойших	Нийт дүн
Яам	30	11	41
Үндэсний хөтөлбөр-Б	9	6	15
Батлагдсан		6	6
Нэмэлт өөрчлөлт хийгдээгүй	9		9
ХБТТ хуульд хамаарахгүй БББ	12		12
Нэмэлт өөрчлөлт хийгдээгүй	12		12
Бодлогын баримт бичиг биш	9	5	14
Батлагдсан		5	5
Нэмэлт өөрчлөлт хийгдээгүй	9		9
Агентлаг	19	4	23
Үндэсний хөтөлбөр-Б	2	2	4
Батлагдсан		2	2

⁵⁴ Хөтөлбөр нэртэй боловч ХБТТХ-ийн 6 дугаар зүйлд заасан ангилалд багтахгүй мөн ЗГ-ын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2016-2020 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх “Үндэсний хөтөлбөр”-ийн жагсаалтад ороогүй,

Нэмэлт өөрчлөлт хийгдээгүй	2		2
ХБТТ хуульд хамаарахгүй БББ	8	2	10
Батлагдсан		1	1
Нэмэлт өөрчлөлт хийгдсэн		1	1
Нэмэлт өөрчлөлт хийгдээгүй	8		8
Бодлогын баримт бичиг биш	9		9
Нэмэлт өөрчлөлт хийгдээгүй	9		9
Grand Total	49	15	64

Хавсралт №6. Анх бүртгэгдсэн болон шинээр бүртгэгдсэн баримт бичгийн тоо

Баримт бичгийн нэр	Хууль батлагдахаас өмнөх			Нийт дүн
	Анх байсан	Хууль батлагдсанаас хойших Анх байсан	Шинээр нэмэгдсэн	
Хөгжлийн үзэл баримтлал		1		1
Төрөөс баримтлах бодлого	23	6	6	35
Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал	1			1
Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр		1		1
Үндэсний хөтөлбөр	37	25	6	68
Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр	1			1
Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл		2		2
Дэд хөтөлбөр	1	1		2
Үндэсний хөтөлбөр-Б	11	8		19
ХБТТ хуульд хамаарахгүй БББ	20	1	1	22
Бодлогын баримт бичиг биш	18	5		23
Grand Total	112	50	13	175

Хавсралт №7. Хууль батлагдахаас өмнөх баримт бичиг /боловсруулалтаар/

Баримт бичгийн нэр	Хууль батлагдахаас өмнөх		Нийт дүн
	Нэмэлт өөрчлөлт хийгдээгүй	Нэмэлт өөрчлөлт хийж байгаа	
Төрөөс баримтлах бодлого	21	2	23
Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал	1		1
Үндэсний хөтөлбөр	35	2	37
Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр	1		1
Дэд хөтөлбөр	1		1
Үндэсний хөтөлбөр-Б	11		11
ХБТТ хуульд хамаарахгүй БББ	20		20
Бодлогын баримт бичиг биш	18		18
Grand Total	108	4	112

Хавсралт №8. Аудитад хамрагдсан баримт бичиг /Яам, агентлаг, боловсруулалтаар/

	Батлагдсан	Нэмэлт өөрчлөлт хийгдсэн	Нэмэлт өөрчлөлт хийгдээгүй	Нэмэлт өөрчлөлт хийж байгаа	Шинээр боловсруулж байгаа	Нийт дүн
Яам	39			4	10	53
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	1					1
Барилга, хот байгуулалтын яам	1				4	5
Батлан хамгаалах яам						
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	2					2
Гадаад харилцааны яам	3				1	4
Зам, тээврийн хөгжлийн яам	1			4	3	8
Сангийн яам	7					7
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	1				2	3
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	7					7
Хууль зүй, дотоод хэргийн яам	2					2
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	6					6
Эрүүл мэндийн яам	7					7
Эрчим хүчний яам	1					1
Агентлаг	7					7
Агентлаг	7					7
Grand Total	46			4	10	60

Хавсралт №9 ХБТТХ хэрэгжиж эхэлсэнээс хойш батлагдсан баримт бичигт өгсөн үнэлгээ

д.д	Бодлогын баримт бичгийн нэр, төрөл	Харьяалагдах яам, агентлаг	Шинжээчийн багаас өгсөн үнэлгээ
1	Монгол улсын тогтвортой хөгжил үзэл баримтлал - 2030 /ХБТТХ-7/	ЗГ	38.70
Төрөөс баримтлах бодлого /ХБТТХ-8/			14.65
2	Барилгын салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого	БХБЯ	0.00
3	Төрөөс газрын харилцаа, геодези, зураг зүйн талаар баримтлах бодлого		0.00
4	Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлого		14.81
5	Төрөөс орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаар баримтлах бодлого		0.00
6	Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого		БСШУСЯ
7	Автотээврийн талаар төрөөс баримтлах бодлого	ЗТХЯ	0.00
8	Төрөөс авто замын талаар баримтлах бодлого		0.00
9	Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого		0.00
10	Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого		0.00
11	Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого	ХХМТГ	28.44
12	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого	ХНХЯ	28.04
13	Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого		25.87
14	Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого	ЭМЯ	41.08
15	Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого	аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга	23.13
Үндэсний хөтөлбөр /ХБТТХ-11/			21.23
16	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	БОАЖЯ	26.29
17	Орлоготой оюутан	БСШУСЯ	27.70

18	Дэлхийн Монголчууд хөтөлбөр	ГХЯ	5.50
19	Монгол Улсыг гадаадад суртачлах хөтөлбөр		5.50
20	Монгол экспорт		0.00
21	Экспортыг дэмжих		1.80
22	Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр	ЗТХЯ	0.00
23	Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр		8.77
24	Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр		0.00
25	Монгол Улсын Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр	СЯ	34.44
26	Хөгжлийн зам үндэсний хөтөлбөр		29.39
27	Эдийн засгийг сэргээх хөтөлбөр		6.20
28	Алт-2 үндэсний хөтөлбөр	УУХҮЯ	35.68
29	Газрын ховор элемент хөтөлбөр		0.00
30	Үндэсний геомэдээллийн сан хөтөлбөр		0.00
31	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр	ХНХЯ	41.84
32	Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр		1.80
33	Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр		29.25
34	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тав дахь хөтөлбөр		41.41
35	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эрэлттэй тэмцэх хөтөлбөр	ХЗДХЯ	28.55
36	Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр		28.44
37	Жимс, жимсгэнэ үндэсний хөтөлбөр	ХХААХҮЯ	34.16
38	Сав, баглаа боодол үндэсний хөтөлбөр		3.60
39	Хүнсний ногоо үндэсний хөтөлбөр		31.02
40	Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр	ЭМЯ	37.28
41	Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр		48.98
42	Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр		37.15
43	Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөр		29.22
44	Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд хөтөлбөр		41.98
45	Эрчим хүч хэмнэх хөтөлбөр	ЭХЯ	29.19
46	Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр	АТГ	24.08
47	Монгол Улсын статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	СтатХ	24.87
48	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр	ШӨХТГ	6.40
49	ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр /ХБТТХ-10/	ЗГ	37.50
Монгол Улсын ЭЗНХҮЧиглэл /ХБТТХ-13/			35.00
50	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл		36.00
51	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл		34.00
Дэд хөтөлбөр /ХБТТХ-15/ /ХБТТХ-д хамаарахгүй/			3.47
52	Мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөр		1.80
53	Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө		0.00
54	Эрчим хүч, зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх томоохон төсөл, хөтөлбөрийн жагсаалт		0.00
55	Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төсөл		0.00
56	Бичил бизнесийг дэмжих хөтөлбөр		0.00
57	Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах богино хугацааны хөтөлбөр		1.80
58	Монгол тариалан хөтөлбөр		1.80
59	Хотжилт ба эрүүл мэнд хөтөлбөр		1.50
60	Үндэсний чанарын хөтөлбөр		24.37
Дундаж хувь			25.09

Хавсралт №10. Хөгжлийн бодлогын баримт бичгийн боловсруулалт, хэрэгжүүлэлтэд оролцогч талуудын чиг үүрэг

Бодлогын баримт бичгийн төрөл	Оролцогч тал					
	Боловсруулах	Хэлэлцүүлэх зөвшөөрөл олгох	Батлах	Хэрэгжүүлэх	Хяналт шинжилгээ, үнэлгээ	Хөндлөнгийн үнэлгээ
Хөгжлийн үзэл баримтлал	ЗГ /хуулийн 7.3./	-	УИХ /хуулийн 7.4./	Нэгдсэн удирдлага байхгүй. Төрийн болон нутгийн захиргааны бүх байгууллага хэрэгжилтэд оролцоно	Төрийн захиргааны төв байгууллага 2 жил тутамд зохион байгуулна /хуулийн 7.5, 7.6 ХШҮ-ны журмын 7.5.1/	Сангийн яам 4 жил тутамд зохион байгуулна /хуулийн 7.7, ХШҮ-ны журмын 7.5.1/
Төрөөс баримтлах бодлого	Сангийн яам /хуулийн 8.2./ Төрийн захиргааны төв байгууллага /хуулийн 8.4./	Сангийн яам /журмын 31/	ЗГ /хуулийн 8.4/	Төрийн захиргааны төв байгууллага /хуулийн 8.5/	Төрийн захиргааны төв байгууллага /хуулийн 8.6, ХШҮ-ны журмын 7.5.2/	Төрийн захиргааны төв байгууллага /хуулийн 8.6, ХШҮ-ны журмын 7.5.2/
Бүсчилсэн хөгжлийн хөгжлийн бодлого	ҮХГ, төрийн захиргааны төв байгууллага /хуулийн 13.2/	Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн ТЗБ /хуулийн 13.2./ Сангийн яам ЗГХЭГ-т оруулна /журмын 32/ Энэ нь хуультай зөрчилтэй	ЗГ /хуулийн 13.5/	Нэгдсэн удирдлага байхгүй. Төрийн болон нутгийн захиргааны бүх байгууллага хэрэгжилтэд оролцоно	Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага /хуулийн 13.6, ХШҮ-ны журмын 7.5.7/ ҮХГ үр дүнг нэгтгэн ЗГ-т танилцуулна	Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага /хуулийн 13.6, ХШҮ-ны журмын 7.5.7/ ҮХГ үр дүнг нэгтгэн ЗГ-т танилцуулна
Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	ЗГХЭГ /хуулийн 9.2/	ЗГ /Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 26.7/	УИХ	ЗГ	Төрийн захиргааны төв байгууллага хийж ЗГХЭГ нэгтгэнэ /хуулийн 9.4, ХШҮ-ны журмын 7.5.3, дэгийн тухай хуулийн 46.1/	Төрийн захиргааны төв байгууллага хийж ЗГХЭГ нэгтгэнэ /хуулийн 9.5, ХШҮ-ны журмын 7.5.3 / хугацаа тодорхойгүй
Үндэсний хөтөлбөр	Төрийн захиргааны төв байгууллага /хуулийн 10.2, 10.3, 10.4 (сангийн яам хамтран)/	Сангийн яам /хуулийн 10.3/	ЗГ /10.3/	Төрийн захиргааны төв байгууллага /хуулийн 10.6/	Төрийн захиргааны төв байгууллага /хуулийн 10.7,	Төрийн захиргааны төв байгууллага /хуулийн 10.7/ хугацаа тодорхойгүй
Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр	30 тэрбумаас дээш бол ҮХГ, 30 тэрбумаас доош бол холбогдох ТЗТБ /төсвийн тухай хуулийн 28.29/	Сангийн яам, ҮХГ	УИХ	Төрийн захиргааны төв байгууллага	ҮХГ 2 жил тутамд /хуулийн 11.4, ХШҮ-ны журмын 7.5.5/	Зохицуулалт байхгүй
Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	Сангийн яам /хуулийн 12.6/	ЗГ /хуулийн 12.7/	УИХ /Хуулийн 12.8/	Төрийн захиргааны төв байгууллага	Сангийн яам /ХШҮ-ний журмын 7.5.6/	Зохицуулалт байхгүй

Хавсралт №11. ХБТТХ-д тусгагдсан хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдаа

